

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРОО

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 13
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	14 – 89
1.	<i>“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	15 – 17
2.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	17 – 77
3.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	78 – 89

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.*

*Томилолттой: Ш.Бямбасүрэн;  
Тасалсан: О.Цогтгэрэл.*

**Нэг. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

**Р.Сэддорж:** “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 10  
Бүгд: 19  
47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

*Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагваа, Үндэсний статистикийн хорооны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ж.Болормаа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Ариунсанаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн

төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, П.Сайнзориг, Б.Мөнхсоёл, Б.Найдалаа, Г.Лувсанжамц, М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Ж.Алдаржавхлан, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ж.Болормаа, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

*Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 18.1 дэх заалтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого, төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууляя.

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 14  
Бүгд: 21  
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын

харгалзах мөрөнд Хэмжих нэгж: Тоо гэж, Суурь он: 2023 гэж, Суурь түвшин: - гэж, Зорилтот түвшин: 200 гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 11  
Бүгд: 21  
47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 9  
Бүгд: 21  
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж: Тоо гэж, Суурь он: 2023 гэж, Суурь түвшин: - гэж, Зорилтот түвшин: 200 гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 11  
Бүгд: 21  
47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**3.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж: Тоо гэж, Суурь он: 2023 гэж, Суурь түвшин: 780 гэж, Зорилтот түвшин: 300 гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 9  
Бүгд: 21

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 17.1 дэх заалтын 17.1.1 дэх заалтад “төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт” гэсэн агуулга бүхий 17.1.1.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж: Хувь гэж, Суурь он: 2023 гэж, Суурь түвшин: - гэж, Зорилтот түвшин: 20 хувь гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 9  
Бүгд: 21

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийг 400 саяар бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургах, стандартыг ашиглаж хэвшүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох төсөлд 400 сая төгрөг зарцуулахаар нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 11  
Бүгд: 21

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 12  
Бүгд: 21

42.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

**6.**Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.25. Баянхонгор Шаргалжуут чиглэлийн 54.18км хатуу хучилттай авто замын санхүүжих дүнг 3 тэрбум төгрөгөөр бууруулж, Баянхонгор аймгийн төвд баригдах дулааны цахилгаан станцын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээний санхүүжих дүнг 3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 7  
Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**7.**Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл нарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийн 11,986.1 сая төгрөгийг 9 тэрбум төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулсан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 14  
Бүгд: 21

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн



даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагваа, Үндэсний статистикийн хорооны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн,

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ж.Болормаа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Ариунсанаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр нь хэлэлцэв.*

1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дуусав.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн хариулж, тайлбар хийв.

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дуусав.

3.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дуусав.

4.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригоос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 11  
Бүгд: 21  
47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21  
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21  
52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

“8/Цэвэр эрчим хүч, хогноос эрчим хүч гаргах асуудлыг зохицуулах, дэмжих, ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийн тухай хууль тогтоомжийн

төслийг боловсруулж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9 дэх дэд заалт нэмэх:

“9/Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

–“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 19 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

**“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэв.**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 9  
Бүгд: 21  
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** “Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 03-ны өдөр баталсан 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын “2025 оны 01 сарын 06-ны өдөр” гэснийг “2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр” гэж өөрчилсүгэй гэсэн Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21  
52.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 19 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 45 минут үргэлжилж, 25 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 92.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 12 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг  
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим  
15 цаг 27 минут

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Р.Батболд гишүүн, О.Батнайрамдал гишүүн, П.Батчимэг, гишүүн Э.Батшугар гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүн, Г.Лувсанжамц гишүүн, М.Мандхай гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, П.Сайнзориг гишүүн, Л.Соронзонболд гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Найдалаа гишүүн, С.Цэнгүүн гишүүн, Д.Энхтүвшин гишүүн, М.Энхцэцэг гишүүд хүрэлцэн ирсэн байна. М.Бадамсүрэн гишүүн хүрэлцэн ирсэн байна. Миний бие. Ирц 64.0 хувьтай байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 64.0 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Нэг.** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2024 оны 12 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

**Хоёр.** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд.

Засгийн газар 2024 оны 12 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Ийм хоёр асуудал Байнгын хороогоор хэлэлцэхээр энэ долоо хоногийн тов дараалалд орсон байгаа.

Өнөөдрийн хурлаар бас нэг асуудлыг нэмэх шаардлагатай байгаа.

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар Байнгын хорооны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Тиймээс Байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудалд “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэхээр нэмлээ. Ганцхан тогтоол байгаа учраас эхэнд нь хэлэлцээд дуусгана.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Д.Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Евро-Азийн хэлэлцээртэй холбоотой тэр мэдээллүүд дээр илүү танилцах хүсэлт тавьсан байгаа. Тэр асуудлын талаар ер нь асуудлаа татчихаад цаг тохирох ёстой юу? Тэр талаар яах вэ?

**Р.Сэддорж:** Тэр мэдээлэл нь дөнгөж өнөөдөр ирсэн байна. Сая ирсэн байна.

Тэгээд ажлын алба ажиллаад ирэх долоо хоногийн хурлаар хамгийн түрүүний асуудал болгож хэлэлцүүлье гэж бэлдэж байгаа юм байна. Тэгж бэлдэж байгаа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байхгүй байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

---

### Нэг.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны ТОГТООЛЫН ТӨСӨЛ

---

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулъя.

Байнгын хорооны тогтоол. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”

---



Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Энэ нөгөө хугацаатай холбоотой л юм.

Тэгээд манай Байнгын хороо ганцаараа нэг сар болгочихсон.

Тэгээд Улсын Их Хурлын намрын чуулган сунгаж хуралдахаас өөр аргагүй болох учраас үүнийг эргэж хараач ээ гэж. 15 хоног Тийм.

1.Монгол Улсын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны гэснийг 2024 оны 12 дугаар сарын 19-ний гэж өөрчилсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл танилцуулж байна.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? П.Сайнзориг гишүүн. П.Сайнзориг гишүүнээр тасаллаа.

П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Уг нь ингээд 30 хоног гэдэг юм уу, жоохон оролцоог хангасан, олон нийтэд ил тод байдлыг хангасан энэ жишгээрээ уг нь явчихмаар байгаа юм даа.

Зайлшгүй үүнийг намрын чуулганаар хэлэлцэх ёстой юм уу? Энэ гишүүдийн сонгон шалгаруулалтыг.

Дараагийн гишүүд нь сонгон шалгаруулалтаа орж иртэл өмнөх гишүүд чинь үйл ажиллагаагаа бүрэн эрхээ хэрэгжүүлээд л явж л байна шүү дээ. Энэ ямар сонирхол байгаа юм бэ? Яг эд ийм баяр ёслолын үеэр нэг бүртгэлийг хааж байгаад л нэг. Эсвэл нэр ус нь тодорчихсон бол тэгээд хэлчхээч. Заавал ийм юм явуулж яадаг юм ер нь. Үүнийг томилно гээд л.

Тэгээд 30 хоног гэдэг юм уу, энэ салбарын хүмүүс жоохон оролцох бололцоог нь хангаад ингээд аваад явчихъя гэхээр заавал ийм сонин юм орж ирээд байх юм.

Тэгээд л үүнийгээ хаврын чуулганд тэр нээлттэй сонсгол энэ тэрийг нь хийчхээд л хаврын чуулганаар тэр гишүүдийг нь томилъё л доо.

Тэгэхээр ийм чухал юмнуудыг яг цаг үеийг нь тааруулж байдгаа больчихмоор байна. Үүнийг дэмжмээргүй байна. Энэ ямар үндэслэлээр ингэж наашлуулаад байгаа юм? Тэрийг л тодруулья даа.

**Р.Сэддорж:** Манай Байнгын хороо ганцаараа 30 хоног болгочихсон юм байна.

Нөгөө хоёр Байнгын хороо бол 14 хоногтой байгаа юм байна. Хууль зүйн байнгын хороо хэлэлцсэн байна.

Тэгвэл даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудлыг оруулж ирээч ээ гэсэн ийм хүсэлт тавьсан. 01 сарын 15-нд чуулган завсарлах боломжгүй болсон байна. Ийм учраас энэ асуудлыг 14 хоног болгож өгөөч ээ гэж даргын зөвлөлийн хурал дээр санал хураалт явуулаад тэгээд олонхын саналаар дэмжигдээд, Улсын Их Хурлын дарга баталгаажуулж өнөөдрийн энэ хэлэлцэх асуудалд оруулж ирж байгаа юм.

Асуулт асууж, санал хэлж дууссан байна. Санал хураалт явуулаад шийдчихье.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

47.4 хувийн саналаар тогтоол дэмжигдсэнгүй.

Санал хураалт явуулж дууслаа.

---

**Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай,  
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд**  
/Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, **хоёр дахь хэлэлцүүлэг,** санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

---

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Сайдын микрофоныг нээе. 5 номер.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль, тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хэлэлцэн баталсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг, мөн цаашдаа үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах чиглэл рүүгээ явах хэрэгтэй байна гээд.

Ийм үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсөн.

Ингээд Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин боловсруулж өргөн барилаа.

Ингээд төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчим баримталлаа.

Нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих, мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн шүүхийн байгууллагууд болон Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудын урсгал зардлыг тус тус бууруулаагүй.

Хоёр.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь буурууллаа.

а/Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь буурууллаа.

б/Соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдралд хөтөлбөрийн зардлыг 100 хувь буурууллаа.

в/Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр, шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар буурууллаа.

г/Дээр дурдсан 5-аас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох дотаци, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

Гурав.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана.

Дөрөв.Гэрээ байгуулаагүй ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна. Зарим эх үүсвэр, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлууллаа.

Гадаад зээлийн ашиглалтыг бууруулах гарцаагүй шаардлага бий болж байна. Мөн хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлууллаа.

“Хавдар судлалын үндэсний төв-II” хөрөнгө оруулалтыг нэмж тусгана.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцож байна. Буурах тийм нөлөө орно гэж тооцож байна.

Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3.3 хувийн эерэг байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын

сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Б.Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Д.Загджав аудиторын микрофоныг нээе.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн, аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой арга хэмжээ олсон байна.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй батлах төсөв батлах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьжээ.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Барилга, хот байгуулалтын сайд, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайд, Зам тээврийн сайд, Эрчим хүчний сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга зэрэг 10 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн орлогыг 529.9 тэрбум төгрөгөөр, зарлагыг 2 их наяд 612.5 тэрбум төгрөгөөр тус улсад төлөвлөжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

1.Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уулын уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөлд өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн асуудлыг бууруулж байна.

3.Цахим систем болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой тогтмол жишиг үнэ, заавар, журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зарлагыг хумьж зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсгэх магадлалтай байна.

5.Төрийн үйлчил үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд нь бүрдүүлэх шаардлагатай байна.

6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно.

Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх Төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Монгол Улсын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжид нийцэхгүй байна гэж аудит дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг Та бүхэнд хүргүүлсэн.

Ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя. Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Д.Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, А.Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Я.Самбуунямбуу Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Д.Ган-Очир Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Б.Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Д.Лхамсүрэн Үндэсний статистикийн хорооны дэд дарга, Б.Лхагваа Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга, Б.Төмөрхуяг Үндэсний статистикийн хорооны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Анар Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, О.Мягмардорж Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга,

Сангийн яамнаас М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Л.Сонор Санхүүгийн бодлогын газрын дарга, З.Энхболд Хууль, эрх зүйн газрын дарга,

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Г.Намчинсүрэн Эрдэс баялгийн бодлогын газрын дарга,

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Ж.Болормаа Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас З.Ариунсанаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Х.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, З.Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга,

Эрчим хүчний яамнаас О.Хуягцогт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга нар тус тус хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

М.Бадамсүрэн гишүүнээр тасалж байна. Н.Батсүмбэрэл гишүүний микрофоныг нэрд нэмье. Н.Батсүмбэрэл гишүүнээр тасалж байна.

Ингээд Ж.Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Би Л.Гантөмөр сайдаас хоёр асуулт асуугаадахъя.

Яах вэ, бид ойролцоогоор 30 их наяд орлого, зарлага 2024 онд байсан бол одоо ингээд 2025 онд бараг 34 хүрэх нь л дээ. Би зүгээр багц дүнгээр нь хэллээ.

Тэгээд энэ бодлогын хүүд яаж нөлөөлөх бол? Ер нь зах зээл рүү мөнгө орох болов уу, орохгүй болов уу?

Би зүгээр сураг сонсох нь. Би тэгээд яагаад Монголбанкнаас асуухгүй байгаа юм гэхээр тойруулчхаж магадгүй гээд танаас асууж байгаа юм. Зүгээр сураг сонсох нь бодлогын хүүг 4 хувиар өсгөнө гэсэн яриа байгаа л юм шиг байна лээ. Ингэвэл бид тэгээд хөдөлж байгаа эсэхээ их боомилно л доо.

Уг нь бол одоо энэ ажил хөдөлмөр хийж хөдөлж байгаа хүмүүс нийгмийн бүхий л асуудлыг шийдвэрлэх үндсэн суурь шүү дээ. Одоо манай гишүүд бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд л тэнд нэг эмнэлэг тавиуллаа, энд нэг юу тавиуллаа гээд.

Тэгээд суурь нь ерөөсөө өөрчлөгдөхгүй. Уг нь бид валютын ханшийг алдах гэж байна гэж айхаас. Мэдээж хэрэг тэр талдаа зохицуулалт байх л хэрэгтэй байх.

Гэхдээ нөгөө талдаа энэ ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсээ яаж төр дэмжих вэ гэдгийг л.



Сүүлийн 3, 4 жил бодлогын хүү маш өндөр явж ирлээ л дээ. Энэ өөрөө зээлийн хүү, тэрийг дааж давдаг, эрийг даваад хөдөлдөг хүмүүсийн хүсэл эрмэлзлийг үнэхээр мохоож байгаа юм л даа.

Тэгээд энэ тал дээр яах вэ гэдгийг бас сонсьё. Л.Гантөмөр сайд үүнийг юу гэж үзэж байгаа бол.

Би Эдийн засгийн байнгын хороон дээр харьяалагдах байгууллагуудаа голцуу асууя гэж бодсон юм. Уул уурхай, эрдэс баялгийн сайдаас асуулт байна. Би саяын хасагдсан зардлуудыг харахаар тэр геологийн суурь судалгааны зардал хасагдчихсан юм уу, үгүй юм уу? Мэдэхгүй байна. Хасагдчихсан юм шиг харагдаж байна лээ. Их богино хугацаанд харлаа л даа.

Тэгээд бид чинь уг нь маш их баялагтай улс. Дараагийн Эрдэнэтийг, дараагийн Эрдэнэс Тавантолгойг, дараагийн Оюу Толгойг олох бүрэн боломжтой.

Тэгээд хуучны тэр нэг геологийн зураглалуудаар хийгээд байдаг. Амжилт бас нэг их тийм үр дүнтэй биш.

Тэгэхээр энэ агаарын геофизикийн ажил. Тэгээд л бусад орчин үеийн технологиудыг ашиглаад баялгаа тодорхойлох, тэрийгээ олон улсад зарлах, түүгээрээ дамжуулаад эрдэс баялгийнхаа салбарын нэр хүндийг өргөх гол зардал л даа. Энэ хасагдсан юм уу, хасагдаагүй юм уу?

Ирэх жилүүдэд тэр хайгуулын тусгай зөвшөөрөл.

**Р.Сэддорж:** Л.Гантөмөр сайдын микрофоныг нээе.

**Л.Гантөмөр:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

2024 он үндсэндээ эдийн засгийг идэвхжүүлэхэд хамгийн хүчтэй түлхэц өгсөн он жил гэж хэлж болно.

▷ **Нэгдүгээрт**, 2024 онд хөдөө аж ахуйг дэмжих зориулалтаар “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг эхлүүлсэн. Энэ хүрээнд зээлийн хүүгийн төлбөрийг төрөөс даасан байгаа.

▷ **Хоёрдугаарт**, ипотекийн зээлийн идэвхжилийг нэмэгдүүлсэн. Энэ хүрээнд ипотекийн зээлийн хэмжээ нэмэгдсэн байгаа.

▷ **Гуравдугаарт**, 2024 оны 4 сараас эхлээд цалин, тэтгэвэр нэмэгдсэн байгаа. Үүнтэй холбогдуулаад зах дээрх мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн.

Тийм учраас эдийн засаг яг дотоод эргэлтийнхээ хувьд маш их сайжирсан. Үүнтэй уялдуулаад импортын хэмжээ их хэмжээгээр нэмэгдсэн байгаа.

Тийм учраас валютын ханшаа алдах вий гэсэн болгоомжлол газар сайгүй яригдаж байна. Валют тодорхой хэмжээгээр. Тодорхой хэмжээгээр шүү. Суларч харагдаж байгаа нь өөрөө эдийн засгийн дарамт гэж Эдийн засаг, хөгжлийн яам бол харахгүй байгаа.

Тийм учраас бид одоо гараад байгаа тоонууд юу вэ гэхээр дотоод гарч байгаа зээлийн хэмжээ 26-аас 30 хувь нэмэгдэж байгаатай уялдуулаад зээлийн хэмжээг бууруулахын тулд бодлогын хүү нэмэгдэх нь гэсэн ийм таамаглал явж байгаа гэж би одоо жишээ нь таны ярианаас ойлгож байна.

Бид Монголбанктэй өнөөдөр харилцаж байгаа харилцааныхаа түвшинд бодлогын хүү нэмэгдэнэ гэсэн ийм дүр зураг бидний хувьд харахгүй байгаа. Харин ч бид энэ удаагийн төсвийн тодотголоор 2.3 их наядыг хасаад орж ирж байна.

Магадгүй төсөв батлагдахдаа дахиад хасагдах тийм чимээ авч байна. Тодорхой зардлуудыг гишүүд бууруулах санал гаргах юм байна гэж ингэж харж байна.

Тийм учраас 2.3 их наядаар ирэх оны төсвийг бууруулж орж ирж байгаа нь өөрөө бодлогын хүү нэмэгдэхгүй байх баталгаа болох ёстой.

Бид төсвийн зардлыг ингэж бууруулахдаа Засгийн газрын баримталсан зарчим бол мөнгөний бодлогыг бодлогын хүүг хэвээр хадгалах, зах зээл дэх мөнгөний эргэлтийг сайжруулах гэдэг цорын ганц зорилт дээр гол зүйл хадгалагдаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Өнөөдрийн байдлаар инфляц 7 хувьтай байна. Тэгэхээр инфляцын мөнгөний бодлогыг нь онилж байгаа нь нэг оронтой тоо байгаа.

Тэгэхээр энэ нэг оронтой тоон дотор инфляц хадгалагдаж байгаа тохиолдолд яаран дааран бодлогын хүү нэмэгдүүлж, зах дээр байгаа мөнгийг Төв банк цуглуулдаг энэ байдал гарахгүй гэдэгт эргэлзэхгүй байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Ц.Туваан сайдын микрофоныг нээе.

**Ц.Туваан:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ агаарын геофизикийн судалгаан дээр манай Ж.Ганбаатар гишүүнийг сайд байх үеэс дэвшилтэт олон улсад хэрэглэдэг маш үр дүнтэй ийм агаарын геофизикийн аргыг Монгол Улсад одоо нэвтрүүлэе гээд.

Яагаад тэгж хэлж байгаа гэхээр бид геологийн судалгаан дээрээ маш их хугацаа алдчихсан. Маш их улс төржсөн байдлаар шийдвэрүүд гаргаж хайгуулын лиценз олголтоо зогсоож ирсэн ийм өмнөх түүхүүд байгаа.

Би нэгхэн тоо хэлчихье. Монгол Улсын одоо газар нутгийн яг өнөөдрийн байдлаар мянган хайгуулын лицензэд нийт газар нутгийн 3.2 хувь орчихсон статистик байгаа.

Тэгэхэд Австрали Улс гээд тэгэхэд одоо уул уурхайн магнайт улс гэхэд газар нутгийнхаа 32.5 хувийг хайгуулын лицензэд өгчихсөн хайгуул судалгаагаа хийгээд явж байгаа байхгүй юу. /минут дуусав/

**Р.Сэддорж:** Ц.Туваан сайдын хариултыг гүйцээе.

**Ц.Туваан:** Тэгэхээр энэ салбар луу мөнгө тавьж ирсэн.

Тэгээд энэ жилийн гүйцэтгэл 60 орчим хувьтай гүйцэтгэгдээд явж байгаа. Энэ дээр янз бүрийн шалтгаанууд байна. Нөгөө хил, хилийн асуудал, онгоцны орж ирэх асуудал энэ тэр гээд асуудлуудаас шалтгаалаад.

Тэгэхээр бид Сангийн яамныханд хэлээд энэ асуудлуудаа эргэж бас тасалдуулахгүйгээр төсвийг нь тавьж өгөөч ээ гэдэг асуудал байгаа.

Ирэх жилийн агаарын геофизик дээр тавьчихсан мөнгө бол энэ жилийнхээ дүнг хадгалаад явахаар байгаа гэдэг хариултыг өгье.

Суурь геологийн судалгааны мөнгө бол төсвийнхөө дагуу байгаа гэдгийг хэлье.

**Р.Сэддорж:** Жамбалын Ганбаатар гишүүн тодруулга.

**Ж.Ганбаатар:** Тэр 40 тэрбумаараа үлдсэн юм байна гэж ойлголоо.

Л.Гантөмөр сайд юу шүү дээ. Бизнесийн зээлийг л би ярьж байгаа юм л даа. Түүнээс биш зах зээл рүү орсон мөнгө гэдэг утгаар нь биш. Яг бизнес хийж байгаа, тэр хүмүүсийн авах гэж байгаа зээлийг л наад хүү чинь өсгөчихдөг. Бодлогын хүү чинь. Тэрийг ярьсан шүү гэдгийг сайн анхаараарай.

Тэгэхдээ ипотекийн зээлийг хүмүүс ингэж хардаг юм шиг байгаа юм. Ипотекийн зээл яг зах зээл рүү ороод бүх юмыг хөдөлгөөд байна. Энэ чинь одоо 80 метр квадратаас доош шүү дээ. Тийм ээ. 100 сая төгрөгөөс доош. Тэрийг нь мартчихаад байдаг юм шиг байгаа юм.

Тэгээд анх удаа байр авч байгаа хүмүүст өгдөг зээл шүү.

Гялс. 1 минут дууслаа. Монголбанк өнөөдөр байгаа үлдэгдэл чинь хэдэн сарын импортод хүрэх юм? Сая Л.Гантөмөр сайд бас хоёр үг хэллээ.

Хуучин энэ чинь одоо юу байлаа даа. Би тэрийг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ц.Туваан сайдын микрофоныг нээе. Дараа нь Монголбанк.

**Ц.Туваан:** Би Ж.Ганбаатар сайдын асуултад яг тодорхой хэлье.

Ирэх жилийн тавигдаж байгаа төсөв бол энэ жилийнхээ түвшинг барина. Нийтдээ энэ жилийн дутуу гүйцэтгэл 15, тэгээд энэ жилийн төсөв дээр 40 тэрбумдаа арай хүрэхгүй. Бага зэрэг танагдаад байгаа гэдгийг хэлье.

Тэгэхээр энэ бол яг 40 тэрбум тавьснаасаа бага зэрэг буурсан гэж ойлгож болно.

**Р.Сэддорж:** Монголбанк хариулъя. 7 номерын микрофоныг нээе.

**Д.Ган-Очир:** Л.Гантөмөр гишүүний асуултад тодруулга өгье. Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир.

Яг одоогийн байдлаар гадаад валютын нөөц 4 тэрбум 950 сая доллар байгаа.

Энэ оны эцэст бид бүхэн 5.2-оос 5.3 тэрбум долларт хүрнэ гэсэн ийм төсөөлөлтэй байна.

Энэ нь яг 5.3 болох юм бол энэ нь бараг 6 сарын импортын хэрэгцээ. Одоогийн байгаа нь 5-аас 5.2 сарын импортын хэрэгцээг хангаж байна гэсэн тооцоо гарч байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Жамбалын Ганбаатар гишүүн хариулт тодорхойгүй байгаа учраас 1 минут өгье.

**Ж.Ганбаатар:** Саяын тэр Д.Ган-Очирын хэлж байгаа зүйл хэрвээ яг үнэн юм бол үүнийгээ сайн хэлж байх хэрэгтэй.

Тэгэхгүй бол хүмүүс чинь төгрөгт үл итгэсэн байдал анзаарагдаад байгаа шүү дээ.

Тийм учраас тийм биш гэдгийг ярих хэрэгтэй. Монгол Улс хангалттай доллартой байна. Ирээдүйд өснө. Цаашдаа өснө. Энэ ханшаа хангалттай барина. Нөөц хангалттай байна. Цаашдаа энэ Ораногийн төсөл явна.

Бусад хөтөлбөрүүд дандаа гаднаас мөнгөө босгоно. Доллар их хэмжээгээр орж ирэх урсгал нэмэгдэнэ. Үүнийг дагаад ер нь төгрөгийн ханш чангарна гэдгийг хэлж байх хэрэгтэй.

Тэгэхгүй бол нэг ингээд болгоомжилсон маягтай байгаад байгаа чинь одоо ингээд хоёр ханш гаргах нэг ийм юм руу оруулаад байна шүү.

Тийм учраас ийм битгий байгаасай гэж хүсэж байгаа шүү. Тэр нүүрсээ хангалттай зар, зэсээ хангалттай зар. Бүрэн боломж байна шүү. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Одоо Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

**П.Сайнзориг:** Би иргэдийг хараад сууж байгаа учраас мэдээлэл өгөх зорилгоор асууж байгаа юм.

Өмнөх буцдаг төсөл дээр ирэх онд орон сууцжуулах бодлогыг дэмжээд ипотекийн зээлийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийг нэлээн боломжийн хэмжээнд тавьж байсан.

Энэ дундаа ногоон орон дээр ипотекийн зээлийг олох эх үүсвэрийг ч гэсэн бүрдүүлж байгаа бодлогын асуудал яригдаж байсан. Одоо дахиж өргөн барихдаа энэ бодлого өөрчлөгдсөн зүйл байгаа юу. Энэ талын мэдээллийг өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт, эдийн засгийг эрчимжүүлж, тэлэлт дээр мөнгө л хэрэгтэй байгаа.

Тэгэхээр бид хэд энэ гадаадын хөрөнгө оруулалттай банкиг оруулж ирэх асуудлыг олон жил ярьж байгаа.

Энэ дээр тэгээд одоо нэг ойлголтоо нэгтгээд юу нь ер нь болохгүй байгаа вэ? Ер нь зүгээр бас тодорхой хэмжээний сонирхогч банкууд ер нь юу явж байгаа юм бэ? Энэ дээр тодорхой Засгийн газрын барьж байгаа байр сууриуд юу байна вэ гэдэг зүйлийг бас нэг хэлж өгөөч.

Тэгээд энэ төсвийн хөрөнгө оруулалтын зардал танагдаж байгаатай холбоотойгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг л нэлээн түлхүү ярина гэж байгаа боловч хууль нь угаасаа чөдөрлөөд тавьчихсан байгаа.

Хуулийг нь сайжруулж байж хувийн хэвшилдээ боломж олгоно. Концессыг ярьсаар байгаад концесс гэдэг нэг хадны мангаатай болсон. Гэтэл хамгийн том эдийн засгийг эрчимжүүлэх хөшүүрэг бол энэ байсан.

Ингээд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ хууль дээр болон энэ зээлийн синдикацыг хослуулах энэ дүр чиглэл дээр ер нь ямар бодлого барьж байна аа? Засгийн газар, Монголбанк хамтраад. Томоохон төслүүдийг нэг банк дангаараа чадахгүй.

Тэгэхээр энэ хэд хэдэн банк, банкнууд энэ нийгмийн даатгалын сантай хорших ч байдаг юм уу. Энэ зээлийн синдикацыг бид институц хооронд нь зөвшөөрөх асуудал дээр ямар бодлогын өөрчлөлтүүд хийж чадах вэ? Ирэх жил дээр.

Дээрээс нь энэ оюуны өмчийн асуудал байгаа. Шадар сайд руу шилжсэн. Аж үйлдвэрийн өмч буюу энэ патентыг энэ аж үйлдвэрийн өмчийг хамгаалж байж бид аж үйлдвэржсэн орон болно. Инновац, техник технологийг бид дэмжинэ.

Тийм учраас энэ оюуны өмчийг хамгаалдаггүй, дэмждэггүй учраас Монголд хөрөнгө оруулалт энэ чиглэлээр орж ирэхгүй.

Дээрээс нь энэ хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнийг ерөөсөө өрсөлдөх чадвартай болгоё гэвэл бас л патент, газар зүйн заалт.

Түрүүн нэг бяслаг яриад байгаа шүү дээ. Ер нь Монгол Улсын хаана ч үйлдвэрлэсэн энэ хүнсний бүтээгдэхүүний онцлогийг шингээсэн өрсөлдөх чадвар, үнэ тарифыг бий болгоё гэвэл энэ газар зүйн заалтын судалгааг төр хийж өгөх ёстой юм. Ингэж байж өөрөө эргээд энэ бяслагийн үнэ цэн ингэж чанар нь дээшилж байгаа, ингэж хүний эрүүл мэндэд сайн гэдэг зүйл яригдах байхгүй юу.

Гэтэл бид нэг ногоон шошго олгож байгаа. Ногоон шошго олгох шаардлага чинь бүр өөрчлөгдчихсэн шүү дээ. Хөдөлмөрийн мөлжлөг явагдаагүй байх, амьтан зовоогоогүй байх ч гэдэг юм уу.

Гэтэл бид нэг дүр эсгэсэн. Монголд ургаж байгаа болгоныг л, химийн бүтээгдэхүүн хэрэглээгүй болгоныг л эко гээд л өөрөө өөрсдөө ч ингээд итгүүлээд байдаг.

Энэ цаашдаа бодлогын өөрчлөлт.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт. Сангийн сайд Болдын Жавхлан. 5 номер.

**Б.Жавхлан:** П.Сайнзориг гишүүний асуултад хариулья.

Ногоон орон сууцын хөтөлбөр үргэлжилнэ. Энэ нэлээн амжилттай суурь нь тавигдсан. Санхүүжилтийн схем нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр хариуцаад явж байгаа.

Илүү боловсронгуй болгох. Дотоодын банкнуудын одоо эх үүсвэр болон МИК корпорацын нэгэнт бий болсон санхүүгийн дэд бүтцийг ашиглаад цаашаа үргэлжлүүлнэ.

Энэ дээр яах вэ, дэд бүтэц талаасаа хувийн хөрөнгө оруулалтуудыг хямдруулах, өртгийг нь буулгах зорилгоор орон нутаг, аймгуудад дэд бүтэц барих. Ялангуяа эндээс нүүж очиж байгаа. Мөн тэндээ тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн албан хаагч нарын нөхцөлийг хангах үүднээс байшинг нь биш зөвхөн дэд бүтцийг нь, газар доорх дэд бүтцийг нь, мөн агаараар татдаг шугам гэх мэт дэд бүтцийг нь тавьж өгөх ийм хөрөнгө Барилга, хот байгуулалтын сайд дээр энэ жил нэлээн хангалттай тавигдсан байгаа.

Сая яах вэ, ингээд тоног төхөөрөмж 20 хувь хасагдаж байгаатай холбогдуулаад хасагдсан. Гэсэн хэдий ч 60 гаруй тэрбум төгрөгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, санхүүжилт яаман дээр үлдэж байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь, Баялгийн сан дээрээс Хөрөнгө оруулалтын сангаар дамжуулаад хуваарилалт. Доор хаяж 300-аас 400 тэрбум төгрөгийн эх үүсвэр нэмэгдэнэ.

Тэр бол ер нь явж явж энэ рүүгээ л дэмжиж чиглэгдэнэ гэдгийг хэлье.

Гадаад бондын хувьд нөхцөл байдал сайжирч байгаа. Бид 10 жил нэлээн муу зээлжих зэрэглэлтэй явж ирсэн. 2013 оноос хойш 11 жилийн дараа тэр үед байсан хамгийн өндөр хүрч байсан зээлжих зэрэглэлдээ бид хүрсэн байгаа. 3 зээлжих зэрэглэлийн агентлаг дээр гурвуулан дээр нь.

Тийм учраас гадаад бонд босгох ажил Засгийн газрын хувьд ч тэр, аж ахуйн нэгжүүдийн хувьд ч тэр нөхцөл сайжирч байгаа.

Сая нийслэлийн 500 сая долларын бонд гарсан. Ер нь дажгүй гарсан. Цаашдаа дахин санхүүжилт хийж зардлыг нь бууруулах. Мөн хувийн хэвшлийн гарчихсан байгаа бондуудын зардал, өртгийг нь бууруулах ийм боломжууд нэлээн тийм таатай байдлаар нэмэгдэж байгаа гэдгийг хэлье.

Ганцхан төр, хувийн хэвшлийн түншлэл ч биш Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль, Гадаад худалдааны тухай хуулиудыг бид шинэчилж, нэлээн либералчилж, хувийн хэвшил, зах зээлийг нь тэлж өгөх боломж руу нь бид өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Нэгэнт төсөв дээрээс томоохон хөрөнгө оруулалтуудыг бид хийхгүй ийм бодлогын шилжилт хийж байгаа учраас аль болох хувийн сектор, гадаадын хөрөнгө оруулалтын идэвхжилийг дэмжих чиглэл рүү явна.

Сая уг нь амжсан бол төсөв дахин боловсруулаад өргөн барихдаа энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийг өөрчлөлт хийгээд барья гэж байсан боловч хараахан амжсангүй.

Хууль бол бас тийм нэг их муу хууль гэж бодохгүй байна. Өмнө нь бид концессын хуультай явсан. Түүнээсээ нэлээн хаширсан. Нэлээн тийм эрсдэл хаасан чиглэлийн ийм хууль болсон.

Бид тэгээд нэг юм болохоор л шуураад хамаагүй суллагч аж болохгүй.

Тэгээд яг зөв дунджийг нь олоод, номер нэг хувийн хэвшил шүү гэдгийг л бодлогоо дэмжээд явах нь зөв өө.

Ингээд тэр синдикац зээл олгох, ер нь хөрөнгө оруулалт хийх, зээл татах энэ боломжит бүх эх үүсвэрийг л бид нэлээн тийм либералчилж өгөх зайлшгүй шаардлага тулгарч байгаа.

Өмнө нь жишээ нь бид баялаг солилцоогоор оффтейк гэж янз янзаар нэрлээд. Оффтейк гэж л ерөөсөө хадны мангаа байдаг юм шиг нэг ийм ойлголт суучихсан. Гэтэл ялангуяа Арабын булангийн орнууд бол энэ баялаг солилцоо буюу одоо энэ “value exchange” энэ хөрөнгө оруулалтын хэлбэрээр их олон жил энэ хөгжлийнхөө өнөөдрийн тодорхой түвшинд хүргэхэд том шийдэл нь байсан.

Гэх мэтчилэн бид төсвөөс гадуур хийж болох. Бид газрын хөрсөн доороо баялагтай байгаад байдаг. Гэтэл томоохон хөрөнгө оруулалтуудаа.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Л.Гантөмөр сайдын микрофоныг нээе.

**Л.Гантөмөр:** Оюуны өмчийн асуудал дээр П.Сайнзориг гишүүнтэй бүрэн санал нэг байгаа.

Бид оюуны өмчөө эдийн засагжуулъя, эдийн засгийн эргэлтэд оруулъя. Энэ нь гадна зах зээл дээр, дотоод зах зээл дээрээ ч гэсэн адилхан эргэлтэд оруулъя гэдэг утгаараа Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд Оюуны өмчийн газар харьяалагддаг болсон байх гэж би хувьдаа харж байгаа. Яг энэ чиглэлээр тодорхой хөтөлбөр гаргаж явна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь энэ орон сууцжуулах ажил манай Засгийн газрын хамгийн чухал ажил байгаа. Бид нарын хамгийн том зорилго бол ямар хугацаанд бид Монгол айл болгон орон сууцад орох вэ гэдэг үндэсний хэмжээний хөтөлбөрийг гаргаж ирэх ийм зорилттой ажиллаж байна.

Тийм учраас Улаанбаатар хот руу одоо бид нарын хамгийн гол анхаарал төвлөрөөд явж байгаа шүү гэдгийг эрхэм гишүүдэд байнга тайлбарлаж байгаа.

Гуравдугаарт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн асуудал дээр тодорхой.../минут дуусав/

**Р.Сэддорж:** П.Сайнзориг гишүүн тодруулга 1 минут.

**П.Сайнзориг:** Тэгээд ипотекийн зээлийн асуудал бол бас тодорхой хэмжээнд үргэлжилнэ. Бас тодорхой шинэ ч бүтээгдэхүүнүүд гарч байгаа гэдгийг бас олон нийтэд мэдээлэл өгөх зорилго байлаа.

Тэгээд ер нь зүгээр энэ оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хамгаалалтын асуудал, наад байгууллагынхаа яг мөн чанарыг нь олох, эргээд энэ бараа, бүтээгдэхүүн, ялангуяа хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэдүүлэхэд тэр газар зүйн заалтын судалгааг нэг хийж өгөөч



ээ. Ялангуяа тэр хөдөө аж ахуйн бүс нутаг гэж зарлачхаад байгаа хэсгүүд дээр нь хийж өгөөч ээ гэдэг зүйлийг би бас хэлмээр байна.

Тэгээд нэг зүйл байна. Ерөнхийдөө энэ төрийн өмчит компанийн реформыг үргэлжлүүлнэ гэдгийг олон талаар сонссон.

Үүнтэй зэрэгцээд яамдтай зэрэгцээд байгаа энэ хороо, комисс, зөвлөлөө татан буулгах ажлыг Засгийн газар шуурхай хийгээрэй. Хэнээс нь хариуцлага нэхэхээ мэдэхгүй байна. Орон сууцжуулалтын бодлогыг хурдасгуур төвийн дарга хариуцах юм уу, эсвэл Эдийн засаг, хөгжлийн сайд хариуцах юм уу, Ж.Батсуурь сайд хариуцах юм уу? Би ерөөсөө бүр мэдээллээ ч авч чадахаа байлаа. Юм асуухаар тэр, энэ гээд байх юм.

Тэгээд сүүлдээ ийм нэг ийм эзэнгүй.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт. Б.Жавхлан сайдын микрофоныг нээе.

**Б.Жавхлан:** Ер нь яах вэ, гэр бүлийн бас томоохон асуудлуудын нэг бол орон сууц, орон сууцжуулах явдал.

Тийм учраас яах вэ, орон сууцжуулах гэдэг талаасаа Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд дээр энэ асуудал шилжсэн. Ногоон санхүүжилт болон барилгын дэд бүтэц, яг барилга угсралтын талаасаа мэдээж чиглэлийн яамд нь өөрсдөө хариуцалгүй яах вэ.

Ер нь Монголбанк дээр байсан нөгөө орон сууцын санхүүжилтийн схемийг хариуцаж байсан тэр функц Гэр бүл, нийгмийн хамгааллын яам руу шилжиж очсон гэж ойлгож болно.

Төсөв дээрээс жишээ нь энэ жил нөгөө орон нутагт төрийн албан хаагч нар болон орон нутгийн одоо хөнгөлөлттэй 3 хувийн ипотекийн зээлийн санхүүжилт 63 тэрбум төгрөг тусгуулсан байгаа. Энэ ирэх жилийн төсөв дээр яг энэ дүнгээр явж байгаа.

Мэдээж төсөв талаасаа яг санхүүжилт энэ бүх юмнууд дээрээ Сангийн яам хариуцаад оролцоод явж байгаа.

**Р.Сэддорж:** М.Бадамсүрэн гишүүнийг асуух гишүүнд нэмээрэй. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

**Б.Мөнхсоёл:** Сайн байцгаана уу? Энэ өдрийн амрыг эрье.

Тэгэхээр бид чуулган дээр нэлээн асуулт асууж, хариулт авсан.

Эдийн засгийн байнгын хороон дээр дахиж ярилцаж байна. Тэгээд давтахгүй байхыг хичээе.

Аль болохоор урсгал зардлаас төсвийн таналтыг хийе. Хөрөнгө оруулалтын төслүүд рүү орохдоо хамгийн гол нь шалгуур үзүүлэлт дээрээ тулгуурлаж ажиллана. Хамгийн гол нь Төсвийн тухай хуулийн заалт болох нөгөө ТЭЗҮ нь батлагдсан ТЭЗҮ нь байгаа тэр хөрөнгө оруулалтын төслүүдийг яг байршуулах ёстой гэсэн ийм ерөнхий зөвлөмжүүд байгаа.

Тэгэхээр миний бас олон удаа давтаж хэлээд байгаа нэг зүйл бол юу вэ гэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Үндэсний аудитын газар тэртээ тэргүй ингээд цаг хугацаа зараад олуулаа хүний нөөцөө дайчлаад ажиллаад гаргачихсан тайлангуудыг сайн ашигладаг байя. Нэг, хоёрхон хоногийн дотор хүлээж авч байгаа энэ тайланг гишүүд сайн харж амжихгүй.

Тэгэхээр энэ тайлангууд дээр сайн ажиллая гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр би Үндэсний аудитын газрын гаргасан тайлангийн 6.24-ийг жишээлбэл хөндмөөр байгаа байхгүй юу. Улсын хэмжээнд тоног төхөөрөмж худалдаж авах нэршлээр багцалсан 253.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээг төсөвлөөд нэмээд оруулаад ирсэн байна гэж байна.

Тэгэхээр энэ дээр би энэ 6.26-тай санал нэг байгаа юм. Жишээлбэл, тоног төхөөрөмж ангиллын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх заалтад нийцүүлж хөрөнгө оруулалтын бус шинж чанартай эд зүйл худалдан авдаг байдлыг зогсоох, багцын задаргааг тодорхой болгон төлүүлэх шаардлагатай гээд.

Задаргаа сайн байхгүй, мэдээлэл дутмаг болохоор нэг талдаа эргээд Засгийн газар буюу Сангийн яамандаа төсвийн ерөнхийлөн захирагчдаа ч гэсэн бас сул талтай шүү дээ. Нөгөө гишүүд чинь юмаа сайн ойлгохгүйгээс болоод та нарын ажилд бас ачаалал үүсэх магадлалтай. Нөгөө талдаа санал гаргахдаа зайлшгүй шаардлагатай эрэмбэ байхгүй, тодорхой хангалттай мэдээлэл байхгүй болохоор буруу хөрөнгө оруулалтын төслүүдийг бас хасах санал гаргаж болно.

Тэгэхээр энэ нь аль аль талдаа уг нь ашигтай ийм дүгнэлтүүдийг Үндэсний аудитын газраас гаргаад байгаа байхгүй юу.

Мөн нэмж хэлмээр байгаа нэг зүйл нь 6.18. Энэ дээр хариулт авмаар байна. 118.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 47.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй шилжих 15 төсөл, арга хэмжээг нэмсэн байна гээд. Нөгөө 8 сарын 30-нд өргөн барьсан төсвөөсөө ялгаатай байдал ингэж орж ирж байна гээд.

Нэгийг нь буцаахдаа нөгөөг оруулж ирэх шалтгаан нь юу байсан бэ гэж нэмж асуумаар байгаа юм.

Тэгээд бид олон жил ярьж байсан. Би бас өөрөө өмнө нь төсвийн анализ хийж байсан. “Нээлттэй нийгэм форум”-д олон жил ажилласан хүний хувьд гол

хөндөгддөг асуудал бас юу байдаг вэ гэхээр хөрөнгө оруулалтын төслүүдийг оруулчихдаг. Гэтэл хугацаандаа амжиж хэрэгждэггүй. Тэрний нэг шалтгаан нь мэдээж ТЭЗҮ нь бэлэн биш.

Хоёрдугаар шалтгаан нь нөгөө бодит байдал дээр хэрэгжих гэж байгаа одоо тендер зарлахаас.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт. Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням.

**Я.Самбууням:** Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулья.

Манай дүгнэлтийн 6.18 дээр заагдсан энэ 15 төсөл, арга хэмжээ нь 8 сарын 30-нд Улсын Их Хурал, Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийн явцад хэлэлцүүлгийн явцад 15 төсөл, арга хэмжээ нэмэгдсэн байна гэдэг энэ тоог хэлсэн байгаа.

Яг энэ сүүлд өргөн барьсан дээр энэ нэмэгдсэн 15, зөвхөн ерөөсөө нэмэгдэж байгаа нь ганцхан энэ Хавдар судлалын эмнэлгийн барилгын ажил нэмэгдсэн байж байгаа. Хөрөнгө оруулалт дээр. Шинэ төсөл биш. Тийм.

Энэ дээр ялгааг нь аягүй сайн ойлгохгүй бол энэ дээр нөгөө шилжих болон бүр анхных нь би энэ 6.16-аас эхэлдэг байгаа юм л даа. Шинээр эхэлсэн 26 төсөл, арга хэмжээнээс 12 төсөл, арга хэмжээ нь төсвийн хэлэлцүүлгийн явцад нэмэгдсэн, 13 төсөл, арга хэмжээ нь өргөн мэдүүлэх үед худалдан авах ажиллагаа нь зарлагдаагүй байсан.

Тэгээд төсөв батлагдах одоо энэ сүүлийн өргөн барьсан 12 сарын 02-нд өргөн барихад гэрээ нь байгуулагдчихсан байсан. Ганцхан төсөл нэмэгдсэн нь Хавдар судлалын үндэсний төвийн их засварын ажил байгаа юм.

**Р.Сэддорж:** Б.Мөнхсоёл гишүүн тодруулах уу? Б.Мөнхсоёл гишүүн тодруулья.

**Б.Мөнхсоёл:** Тэр Хавдар судлал дээр ойлгож байна.

Саяын сүүлийн 6.24-ийг би хөндсөн. Тэгээд түүнтэй холбоотой дараагийн заалт.

Ер нь нэмж танахдаа одоо тусдаа ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Энэ богино хугацаанд бүх гишүүд давхар ажиллаж хараахан амжихгүй байгаа.

Тэгээд энэ болгоныг хэлэлцэж байх явцад ажлын хэсэг 6 бүлэг, дэд хороо болон ажиллаж байгаа юм билээ. Магадгүй бид нарын асууж байгаа болон асуугдаагүй олон асуудлууд дараа нь тэртээ тэргүй орж ирэх байх.

Тэгэхээр зүгээр 6.24-тэй холбоотой хариулт аваад орхиё.

**Р.Сэддорж:** 3 номер.

**Я.Самбууням:** Салбарын яамд нь тоног төхөөрөмжийнхөө нэршлийг нь нэг бүрчлэн задгайгаар оруулж ирэхгүйгээр бөөн дүнгээр нь багцалсан дүнгээр тоног төхөөрөмж гэдэг нэршлээр оруулж ирээд байна. Энэ нь нийцэхгүй байна л гээд байгаа юм.

Үүнийг төсвийн ерөнхийлөн захирагчид задалж яг тоног төхөөрөмжийнхөө нэршил бүрээр нь задалж оруулж ирээд л байршил болон нэр төрлөөр нь задлуул л гэсэн санаагаар хэлж байгаа юм.

**Р.Сэддорж:** Дараагийн гишүүн Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

**Б.Найдалаа:** Төсвийн захиран зарцуулагч нар энд сууж байх шиг байна.

Ерөнхий нэг асуулт байна. Жишээлбэл, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайд дээр 31 хувь хассан байгаа юм. 22 тэрбум.

Эдийн засгийн хөгжлийн сайд, Тэргүүн Шадар сайд дээр 52.3 тэрбум гэх мэт гээд явж байна л даа.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд дээр 71.8 тэрбум гээд.

Асуулт нь эдгээр зардал сайд нар Та бүхний ажилд баталсан Засгийн газрын хөтөлбөрт тусгасан ажлуудыг гүйцэтгэхэд ямар нэгэн нөлөө үзүүлэх үү гэж байгаа юм.

Хоёрт нь, хасуулмааргүй байсан, үнэхээр болохооргүй байсан зардлыг хассан тохиолдол байна уу? Энэ нэг асуулт байна.

Хоёр дахь нь, Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр сайдаас асуумаар байна л даа.

Шинжлэх ухааны академийн талаар Та хариуцаж байгаа. Зүгээр боловсролын юунаас салгачихсан байгаа юм. Одоо Шинжлэх ухааны академийг цаашид шинэчлэх, хөгжүүлэх, их дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгаатай уялдуулаад хөгжүүлэхэд ямар өөрчлөлт шинэчлэлт хийх вэ? Энэ бол маш том ийм суурь асуудал байгаад байгаа юм л даа. Их сургуулиуд нь тэнд судалгаа хийгээд байдаг. Энд академи гэж байдаг. ХХ зууны үеийн бүтэц байдаг. Гэхдээ болохгүй гэсэн юм бол байхгүй. Зүгээр ямар бодлого, бүтцээр үүнийг өөрчлөх вэ. Төсөв дээр нэлээн үүнтэй холбоотой юм ороод ирсэн байна. Бас танагдсан харагдаж байна.

Тэгэхээр үүнтэй холбоотой та энэ дээр ямар бодлого баримталж байгаа талаасаа дурдаж өгнө үү гэж байгаа юм.

Гуравт нь, Монголбанкнаас нэг асуулт байна. Монгол Улсын төсөв ийм том дүнгээр эргэж буцаад дахин өргөн баригдаад 2.4 их наядаар танагдсан тохиолдол байхгүй.

Тэгэхээр үүний цаана нөгөө эдийн засгийн хүлээгдэж байгаа үр дүн, гүйцэтгэл, дотоодын нийт бүтээгдэхүүн, өөр юу гэдэг юм бусад үзүүлэлтүүдэд ямар нэгэн байдлаар нөлөөлж байгаа юу? Та бүхний судалгаан дээр юу байгаа вэ? Жижиг том огт нөлөө байхгүй юу? Шууд болон дам утгаараа. Ийм байна.

**Р.Сэддорж:** Л.Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Баярлалаа. Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид нарын хасагдаж байгаа төсөв бол үйл ажиллагаанд нөлөөлнө шүү дээ. Гарцаагүй нөлөөлнө. Бид нарын хүрэх гэж байгаа зорилтоос ухрааж байгаа. Ухарна.

Ялангуяа Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад байгаа мөнгөнөөс хасагдаж байгаа дүн шинжлэх ухаан дээр хойшоо ухарна. Ухарна гэдэг нь урагшаа алхах гэж байсан алхалт маань саарна гэсэн үг.

Тэгэхээр бид одоо шинжлэх ухаан дээр яаж мөнгө босгох вэ гэдэг цоо шинэ бодлого бодож эхлэхээс өөр аргагүй байдалд хүрч байгаа.

Ер нь өнгөрсөн хугацаанд шинжлэх ухаанд хийсэн хамгийн том хөрөнгө оруулалт бол судалгааны нэгдсэн цогцолборын барилгыг ашиглалтад оруулахад нэлээн ойлгогдохсон байгаад байгаа юм.

Тэгээд хэрвээ энэ цогцолбор ашиглалтад орох юм бол үүнийг түшиглэсэн шинжлэх ухааны паркийн хөгжүүлэлтийг бид төлөвлөөд байгаа юм.

Ер нь цаашдаа Монгол Улсад энэ шинжлэх ухаан яаж хөгжих вэ гэхээр парк дээр л хөгжинө. Шинжлэх ухааны паркууд бодитой бий болно. Тэнд хөрөнгө оруулалтын шинэ орчин бий болгох учиртай. Шинжлэх ухааны паркийн хөгжүүлэлтэд зориулсан хөрөнгийн санхүүжилтийн хэмжээнээс хамаараад Монголын шинжлэх ухаан бодитой инновац гаргах уу, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх үү, хөгжлийн замыг заах уу гэдэг асуудал бол их тодорхой болно.

Зүгээр академийн бүтэц дээр мэдээж эргэлзээтэй зүйл олон бий. Тэгэхдээ бидний барьж байгаа полиси эхний ээлжид энэ Шинжлэх ухаан, технологийн шинэ батлагдсан хуулиа нэг ажил хэрэг болгох гээд үзье. Зэрэгцүүлээд паркийн хөгжүүлэлтийг хийе.

Тэгэхээр паркийн хөгжүүлэлт хийхээр судлаачид, эрдэмтэд, санхүү, хөрөнгө оруулагч гээд эдгээр зүйлс хаанаа илүү амь орж байна вэ тэр лүүгээ шингэх

учиртай юм билээ л дээ. Зүгээр хасаад хаячихъя гэдэг бодлого сүүлийн 20 гаруй жил ер нь бол их сургууль дээрээ л судалгаа хийе гэдэг зүйл рүү явсан. Би ч өөрөө их сургуулиудаа судалгааны сургууль болгож хөгжүүлэхийн төлөө зүтгэсэн. Харамсалтай нь жишээлбэл их сургуулиудын удирдлагыг хараат бус болгоод хууль батлахаар сайд нь буусны дараа хуулийг нь өөрчлөөд их сургуулийн удирдлагыг хараат болгочихдог л юм байна лээ л дээ.

Тэгээд ингэхээр бас дахиад итгэл алдарч байгаа юм.

Тийм учраас бид паркаа яаж олон нийтийнх байлгах вэ, олон талын хөрөнгө оруулалттайгаар хийх вэ гэдэг дээр л бодлогоо бодно. Энэ дээр олон улсын түвшинд хамтын ажиллагааг хөгжүүлээд ингээд цаашаага алхана гэдгийг танд хэлье.

Ер нь энд мөнгө хасагдлаа хасагдлаа гээд үйл ажиллагаа доголдсонгүй гэдэг яриа бол байхгүй шүү. Яг хасагдаж байгаа хэмжээгээр үйл ажиллагаа саарч байгаа юм. Судалгааны зардал тэрбум төгрөгөөр багасаж байгаа. Яг энэ хэмжээгээр судалгаа хийгдэхгүй. Тэр тухайн цогцолборын санхүүжилт багасаж байгаа. Энэ хэмжээгээр цогцолбор маань ашиглалтад орох хугацаа хойшилно. Бид ирэх оны гэдэг юм уу, 2026 оны төсөв, төлөвлөгөөн дээрээ анхааръя гэдэг бодолтойгоор хандаж байгаа.

Ер нь яагаад Засгийн газар танана гэдэг дээр ингээд эерэг хандлага гаргаж байгаа вэ гэхээр импорт нэмэгдээд байна.

2024 оны сонгуулийн жилийн эдийн засгийн халалт өөрөө 2025 ондоо очоод инфляцыг хөөрөгдөх, төгрөгийн ханшийг сулруулах гэдэг ийм хоёрхон болгоомжлол дээр ухарч байгаа шүү дээ.

Түүнээс биш бид үйл ажиллагаагаа эсвэл бүрэн зогсооё, эсвэл гүйцэд алхъя гэдэг хувилбар биш. Ямар ч байсан бид санхүүгийн зах зээлээ контролтойгоор цаашаага давъя. Үүний ар дээр яг энэ халсан эдийн засгийнхаа түвшинд зах дээр байгаа мөнгөнийхөө хэмжээнд манай эргэлт дотоод эргэлт сайжрах юм бол цаашаага бид алхаад явна гэсэн ийм л төлөвлөгөөтэй байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Тодруулах юм уу? Б.Найдалаа гишүүн 1 минут.

**Б.Найдалаа:** Ямар ажил алдагдах талаар бусад сайд нар хариулаасай гэж бодож байна л даа. Тэгэхгүй төсөв хасчхаад дундаа хаячхаж байгаа юм.

Зүгээр нэг юм. Энэ дээр тодруулаад санал хэлэхэд энэ төсөв ийм томоор танагдаж байгаа нь өөрөө хоёр зүйлтэй байгаа байхгүй юу. Нэг бол төсөв боловсруулж байгаа алдаа байна. Тэнд маш том алдаа байна. Нэг бол ажлаа танаж байгаа юм. Энэ хоёрын гарцаагүй аль нэг нь байхгүй юу.

Тэгэхээр томоор танадаг, дахин өргөн барьдаг энэ асуудал явж явж Их Хурлын асуудал биш Засгийн газрын асуудал байгаа юм.

Тэгээд цаашдаа анхаарахгүй засаг дээр хамаг төсөв хийж байгаа юм чинь энэ өргөн барьж байгаа, боловсруулж байгаа чадавхыг сайжруулахгүй бол Их Хурал дээр засах, засварлах боломж маш бага.

Тийм болохоор цаашаа бас энэ дээр тал талдаа анхаарах ёстой гэж бодож байна. Бусад сайд нар саяын Л.Гантөмөр сайд шиг хариулбал их сайн байна. Юу алдагдаж байгаа юм, юу зогсож байгаа юм. Хасмааргүй зардал юу байсан юм гээд.

Монголбанкнаас.

**Р.Сэддорж:** Ц.Туваан сайд эхлээд, дараа нь Б.Жавхлан сайд, тэгээд Монголбанк хариулъя. Ц.Туваан сайд.

**Ц.Туваан:** Бид бүхэн төсвөө нэлээдгүй өөдрөгөөр төлөвлөөд батлаад гарсан. Мэдээж дараагийн процессуудыг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр бид Засгийн газар дээрээ бүгдээрээ ярилцаад дундаа энэ асуудлуудаа кабинет дотроо ярилцаад шийдсэн. Манай хувьд тийм сүрхий их хэмжээтэйгээр хасагдсан, бодлогод нөлөөлөхөөр хасагдсан зардал байхгүй.

Ер нь мэдээж дотроо яриад хасагдсан зүйл байгаа. Тэрийгээ бид бүхэн үргэлжлүүлээд дараа дараагийн бодлогууд дээрээ яриад явна.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг.

Өргөн барьсан төсөв дээрээ кабинетаараа ярьж байгаад шийдсэн зүйл байгаа. 2024 оны 8 сард Монгол Улсын Их Хурлаар бид ирэх 4 жилийнхээ хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулсан байгаа.

Энэ төлөвлөгөөндөө хүрэх л, үүнийг санхүүжүүлэх ийм төсвийг өргөн барьсан.

2.4 их наяд үндсэндээ яг жигд 33, 33, 33 хувиараа, зээлийн ашиглалт 33 хувь, хөрөнгө оруулалт 33 хувь, урсгал зардал 33 хувь гэж тараагдсан байгаа.

Ингээд өөрөөр хэлбэл бид Засгийн газрын бидний эцсийн зорилго бол энэ хөгжлийн зорилго байгаа. Хөгжлийг санхүүжүүлэх ийм л төсөв өргөн барьдаг.

Харин мөнгөний бодлого болон бусад гаднын нөлөөллөөс тодорхой хэмжээний эрсдэл учирч болзошгүй байна гэдэг товчхоноор ингэж Ерөнхийлөгчийн хориг дээр ч дурдсан. Мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Их Хурал дээрээс Их Хурлын.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Б.Жавхлан сайдын микрофоныг нээе. Гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Тийм.

Тэгээд ингээд хөгжлийн асуудлууд хөгжлийн зорилтоо ярих юм бол одоо ингээд тооны хувьд саарна. Зорилтын хувьд хойшилно. Ийм зүйлүүд гарна. Эрсдэл талаасаа.

Мөнгөний бодлого талаасаа харж байгаа эрсдэлүүд дээр мэдээж сөрөг нөлөөллүүд нь буурна.

Ингээд тэнцвэртэй хөгжлөө бариад бид урагшилна. Үүнийг одоо аль аль талаас нь аль болох бид эерэг талаас нь хараад. Үүнийг харин нөхөх бусад өөр бодлогуудаа бид цаг алдалгүй хийе гэж байгаа. Ялангуяа хөрөнгө оруулалт болон энэ зээл, гадаад тусламж, гадаад хөрөнгө оруулалтуудын олон талт олон эх үүсвэрүүдийг бид илүү их ашиглах.

Дээрээс нь газрын баялгаа заавал төсвөөр биш өөр байдлаар, улсын шилдэг практик туршлагууд байна. Баялаг солилцооны ч гэдэг юм уу. Ийм боломжууд дээрээ нэлээн либерал эрх зүйн болон практик дээрээ өөрчлөлт гаргаад ингээд хөгжлийн зорилтуудаасаа ухрахгүй урагшильъя л гэж байгаа.

**Р.Сэддорж:** 7 номер. Монголбанк Б.Баярдаваа захирал.

**Б.Баярдаваа:** Та бүхний оройн мэнд хүргэе.

Монголбанкны зүгээс байнга л ер нь төсөв бага байх ийм байр суурийг илэрхийлж байдаг. Энэ утгаараа Монголбанк энэ төсөв дээр хийгдэж байгаа өөрчлөлтүүдийг дэмжиж зөв зүйтэй алхана гэж харж байна.

Ер нь эдийн засгийн нийт байгаа хүчин чадлыг төрийн сектор, хувийн сектор аль аль нь л хувааж ашиглана.

Тэгэхээр зэрэг төрийн сектор бага байх тусам л хувийн сектор дээр орон зай нэмж үүсэх учраас энэ зүйл нь зөв зүйтэй алхам гэж ойлгож байна.

Тэгээд тэр утгаараа энэ хийгдэж байгаа алхам гадаад болон дотоод зах зээл дээрх хөрөнгө оруулагч нарт эерэг мессеж болж очих байх. Мэдээж хэрэг гадаад орчны нөхцөл байдалтай уялдуулаад бодлогын тохиргоог цаг тухайд нь хийгээд явах ийм шаардлага үүсэж магадгүй.

Ер нь Ерөнхийлөгчийн хориг дээр ч бас дурдсан байгаа. Гадаад орчны нөхцөл байдалтай холбоотойгоор, олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор тодорхой бус байдал их төвөгтэй байгаа, өндөр байгаа учраас.../минут дуусав/



**Р.Сэддорж:** Нэмж хариултаа гүйцээчихье. 7 номер.

**Б.Баярдаваа:** Тодорхой бус байдал өндөр байгаад байгаа учраас аль болох нөөцтэй, буфертэй байх нь зүйтэй гэсэн ийм байр суурийг илэрхийлсэн.

Тэгээд үүнтэй холбогдуулаад арга хэмжээ хийгдэж байна гэж ойлгож байна.

**Р.Сэддорж:** Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Оройн мэнд хүргэе. Нийтдээ 9 асуулт байна.

Тэгээд дундаас нь тасарчих юм бол тодруулах хэлбэрээр асуугаад явчихъя.

Эхний асуулт. Сангийн яам төсвийн танилцуулгыг 30 орчим хуудастайгаар бэлдээд татварын орлого, мөн зарцуулалт нь хэд байх юм, хувийн хэвшлийг яаж дэмжих вэ гэсэн маш тодорхой танилцуулга бэлдсэн байгаа.

Эдийн засгийн байнгын хороонд харьяалагддаг яамд ийм танилцуулга хийх боломжгүй байдаг юм уу? Ялангуяа Хот байгуулалт, Эрчим хүчний яам, Зам, тээврийн яамдын хариуцаж байгаа дэд бүтцийн байршил, хүчин чадал, сүлжээ, хангамжийн байдал зэргийг байр зүйн зураглалтайгаар, тайлбартайгаар, нэгдсэн хэлбэрээр бэлдэж танилцуулах хэрэгтэй байдаг. Жишээ нь, Хот байгуулалтын яаманд цэвэр бохир усны дэд бүтэц нь харьяалагдаад, Эрчим хүчний яаманд цахилгаан дулаан нь харьяалагддаг.

Ингээд тус тусдаа болохоор төсвийн хөрөнгө оруулалт нь тарамдаад дэд бүтцийн бүрэн бүтэн байдлыг хангаж чаддаггүй.

Цэвэр бохир усны шугам татчихаад байхад дулаан цахилгаан нь байдаггүй, эсвэл цахилгаанд холбогдоод байхад цэвэр ус нь байдаггүй.

Аж үйлдвэрийг хөгжүүлээд хувийн хэвшлийг дэд бүтцээр хангаад, ялангуяа орон сууцын нийлүүлэлтийг дэмжье гэж байгаа бол “One Plan Policy” буюу “Нэгдсэн төлөвлөлтийн бодлого” бид нарт хэрэгтэй. Үүнийг хийх үү? Нэгдсэн байдлаар та бүхэн ингэж танилцуулах уу?

Хоёрдугаар асуулт. Эрчим хүчний яамнаас 3 асуулт байна.

Сая цахилгааны үнийг нэмсэн. Тэгээд төлбөр нэмсэн нь эрчим хүчний салбарын реформ гэж нийгэмд ойлгогдоод байна. 11 сард Эрчим хүчний зохицуулах хорооноос мэдээлэл авсан. Одоогийн байдлаар эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын хөрөнгийн өгөөжийн зорилтот түвшин гэсэн зүйл тодорхойлоогүй байгаа.

Энэ салбарт хөрөнгө оруулах гэж байгаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бас тодорхойлоогүй. Ийм байдлаар эрчим хүчний реформ

хэрэгжих боломжгүй. Тэгээд төсвийн төсөлд ч гэсэн энэ дурдагдаагүй байна л даа. Үүнийг хэзээ тодорхой болгоод эрчим хүчний салбарын реформынхоо бодлогыг тодорхой болгох вэ?

Дараагийн асуулт. Нийслэлд олон айл өрхүүд байшин, гэрээ дулаалаад, цахилгаан халаагуур тавиад утааг бууруулах арга хэмжээг чадал чадлаараа энд тэнд аваад байгаа шүү дээ. Гэтэл цахилгааны хүчдэл нь хүрдэггүй. Байшингаа халааж дийлэхгүй тэгээд буцаад галлагаандаа шилжээд байгаа өрхүүд нэлээн олон байгаа.

Энэ чадал, сүлжээний бүрэн байдлыг хэзээ хангах вэ? Хавсралт 2-оос харахад нийслэлийн гэр сууринд төлөвлөж байгаа төсөв байхгүй байна.

Хавсралт 1-ээс бас нэг асуулт байна. 33.1.5. 10 сард бас би асууж байсан юм. Тэгээд бодитой хариулт аваагүй. 10 сард орж ирсэн шалгуур үзүүлэлт нь яг тэр чигээрээ орж ирээд байна.

33.1.5 дээр цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлт эдлэх айл өрхийн тоо гэж байгаа. 210 мянга байгааг одоо 223 мянга болгоно гэж байгаа. Энд ямар хэмжээний төсөв мөнгө зарцуулах вэ? Тэгээд ямар үр дүнгээр хэмжих гэж байгаа юм бэ? Шалгуур үзүүлэлт нь юу байх юм бэ гэдгийгээ тодорхой болгож өгөөч ээ.

Зам, тээврийн яамнаас. Нийтдээ 3.6 их наядаар 96 барилга байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын төсөл төлөвлөсөн байна. Ийм их хэмжээний хөрөнгө оруулалтад хот суурин газрын хүн ам, тээврийн хэмжээ зэрэг тодорхой шалгуур үзүүлэлттэй байх ёстой байх. Ямар үнэлгээ, эрэмбээр эдгээр төслүүдийг сонгосон бэ?

Үлдсэнийг нь дараа нь асууя.

**Р.Сэддорж:** Ж.Батсуурь сайд хариулна. Түрүүнд Б.Мөнхсоёл гишүүний асуултад дутуу хариулсан байна гэж байна. Сангийн яам бэлдэж байгаарай.

Ж.Алдаржавхлан гишүүнийг энэ нэрсэнд оруулъя. Асуулт асуух нэрсэнд оруулъя. Ж.Батсуурь сайд.

**Ж.Батсуурь:** Тийм. Тэгэхээр орон сууцын асуудал бол олон талт олон салбарын үйл ажиллагаа байгаа юм. Яг үнэндээ 3 намын мөрийн хөтөлбөрт 150 мянган хүртэлх айлын орон сууц ашиглалтад оруулна л гэсэн байгаа.

Тэгээд бид 60 мянган айлын орон сууцыг л ипотекийн зээлээр, бусдыг нь арилжааны, түрээсийн, мөн амины орон сууцыг ипотекийн зээл олгох замаар улс орон даяар барина гэсэн тооцоо хийж байгаа.

Гэхдээ орон сууц ярих юм бол ерөөсөө эрчим хүчний дутагдал, цахилгааны дутагдал, дулааны эрчим хүчний дутагдал.

Ингээд мөн зам тээвэр, бүх хамааралтай байгаа учраас Үндэсний хороо байгуулсан. Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний хороо байгуулж, өөрийн чинь асуугаад байгаа энэ олон салбарын уялдаа холбоог.

Анхны хуралдаанаа хийсэн. анхны анхны хуралдаанаар ерөнхий зүг чигээ гаргаж ирж авсан. Жишээлэх юм бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэхэд юу гэдэг юм эх үүсвэр талаа, манай Хот байгуулалтын яам нийлүүлэлт талаа гэдэг юм уу. Эрчим хүчний яам яг яах ёстой юм бэ. Эрчим хүчний дулааны хэрэглээн дээр очоод л орон сууц зогсож байгаа.

Тэгэхээр хэсэгчилсэн дэд бүтэц буюу одоо энэ Улаанбаатар хот, тойруу шиг Сэлбэ дэд төв энэ тэр гэдэг шиг. Ийм байдлаар асуудлаа шийдье гэсэн. Ингэж явж байгаа.

Тэгэхээр ер нь нэгдсэн байдлаар нэг хуралдаж, нэгдсэн агуулга нь. Сая П.Сайнзориг гишүүн ч гэсэн энэ хурлын өмнө бид нараас асууж байсан. Та нарын бодлого чинь хаанаа яваад байгаа юм бэ?

Тэгэхээр бодлогыг нэгтгэх зорилгоор Орон сууцын Үндэсний Хороо, тэгээд ажлын албатай ийм болоод, тэгээд тодорхой хэмжээнд гадна, дотнын судалгаануудыг хийгээд явж байгаа.

Манай яаман дээр яаралтай 3 хууль өөрчлөхгүй бол болохгүй байгаа юм.

Барилгын тухай хуулийг яаралтай өргөн барих, Үндэсний орон сууцны тухай хуулийг яаралтай өргөн бал барих. Нөгөөдөх нь Хот байгуулалтын тухай хуулийг яаралтай өргөн барихгүй бол өнөөдрийн орон сууцын эрэлт, нийлүүлэлтийн асуудал, барих эдгээр асуудал эрх зүйн хувьд чөдөр тушаа болчихсон асуудлууд байгаа юм.

Тийм учраас та ч гэсэн бид нартай энэ мэдээллийг олон удаа солилцож Сингапур, бусад орнуудын туршлагыг ч гэсэн бид нартай ажлын хэсэгт орж явж байгаа хүний хувьд хэдүүлээ бодлогоо нэгтгэх Үндэсний хороон дээрээ энэ асуудлуудаа нэгтгэхгүй бол зөвхөн орон сууцыг барилаа гээд эх үүсвэр хаана байлаа.

Одоо ингэчихсэн асуудлууд зөндөө л байна л даа. “Залуус-I, II”, “Солонго-I, II”, “1008 айл” гээд ирэх жил ашиглалтад оруулъя гээд тэгэхэд одоо 25 хувийнхаа дулааныг өгнө өө. Үлдсэнийг нь өгч чадахгүй ч гэдэг юм уу. “Залуус”-ыг бариад 5 мянган айлийг ашиглалтад оруулъя гэхэд дулааны эх үүсвэр нь байхгүй ч байдаг юм уу.

Аймгуудын зорилтод 1000, 960 гээд ингээд байж байгаа. Тэгэхдээ дулааны эх үүсвэр, цахилгааны эх үүсвэр дээр очиж байнга гацаж байгаа. Энэ асуудлыг цогцоор нь шийдэх асуудлуудыг Үндэсний хороон дээр ярьж шийдэхгүй бол дан

ганц Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам юм уу, эх үүсвэр талыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яриад амжилтад хүрэхгүй.

Тийм учраас үндэсний хороон дээр үндэсний хэмжээнд ярих л ийм асуудлууд байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Гэхдээ ер нь зорилтот түвшиндээ хүрэхэд цахилгааны нийлүүлэлт, эрчим хүч, дулааны нийлүүлэлтээ хийхэд бусад байдлуудаар асуудлыг шийдчих бүрэн боломжтой гэж үзэж байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Эрчим хүчний яам. О.Хуяцогт дарга. 7 номер дээр.

**О.Хуяцогт:** Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуяцогт.

Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Ер нь 2025 оны төсвийн төсөлд эрчим хүчний салбарын төсөв, урсгал зардал анх 115.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөн байсан. Энэ нь өргөн барьсан төслөөр урсгал зардал 102.0 тэрбум төгрөг болсон байгаа.

Энэ жилийн төсөвт гол баримталсан зарчим 2024-2025 онд шилжиж байгаа энэ цаг үе дээр эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөгт нь нийцүүлэх ийм чиглэлийг Засгийн газар, Эрчим хүчний зохицуулах хороо бие даасан байгууллагатай зөвшилцөж холбогдох тооцоо судалгааг Эрчим хүчний шинэчлэлийн Үндэсний хорооны манлайлал дор хэрэгжүүлсэн.

Ингээд гол төсвийн дотаци бол.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя. 7 номер.

**О.Хуяцогт:** Тэгэхээр нийт урсгал зардлын 85-аас ер орчим хувь нь эрчим хүчний салбарт төрийн өмчийн компаниудад олгож байдаг дотаци байдаг. Манай сайдын багцын хувьд.

Тэгэхээр энэ дотацийг өнгөрсөн жилүүдэд эрс нэмэгдэж ирсэн.

Ингээд үнэ тарифын өөрчлөлт хийгдсэнээр төсвөөс олгож байгаа дотацийг бууруулах зорилттой. Одоо энэ шилжилтийн зохицуулалт явж байна.

Ингээд дотаци буураад зөвхөн төрөөс иргэдэд олгох шөнийн тарифын хөнгөлөлт, хүлэмжийн аж ахуй эрхэлж байгаа би аж ахуйн нэгжүүдэд олгодог хөнгөлөлт үлдсэн. Бусад шилжилтийн зардал гээд дулааны станцуудын үнэ тарифын хэрэгжүүлэх хугацаа хойшилсонтой холбоотой зардал байгаа.

Ингээд энэ зардлууд өмнөх жилүүдээсээ эрс буурсан. Баярлалаа.

**Р.Сэддорж:** С.Батболд Зам, тээврийн яам. 7 номер.

**С.Батболд:** Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд.

Манай дээр саяын таны асуусан 3.6 их наяд бол 2019 оноос хойш явж байгаа нийт төслийн өртөг байгаа.

2025 онд хасагдаад 14 төслийн 281 тэрбум төгрөг нь л шинэ ажил байгаа. Бусад нь 2019 оноос хойш явж байгаа ажлуудын санхүүжилт байгаа. Тийм.

**Р.Сэддорж:** Тодруулга авах уу? Г.Лувсанжамц гишүүн тодруулга.

**Г.Лувсанжамц:** Тийм. Асуусан асуултад бүрэн хариулт авсангүй л дээ.

Эрчим хүчний яамны төрийн өмчит компанийн менежментийг хэрхэн сайжруулах юм бэ? Хөрөнгийн өгөөжийг ямар болгох юм бэ? Тийм тооцоолол нь яг бодитоор зорьж байгаа тоо байгаа юм уу?

Хоёрдугаарт нь, Зам, тээврийн яаман дээр 14 төслийг 280 тэрбумаар сонгосон гэж байгаа юм. Ямар шалгуур үзүүлэлт эрэмбэллээр үүнийг олгоод сонгосон юм бэ гэсэн асуулт.

Сая Ж.Батсуурь сайдын хариултаас харахад орон сууцын үндэсний хорооны бодлогыг Эдийн засгийн байгаа хороон дээрээ нэгдсэн төлөв байдлаар мэдээлэл авах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Тэгээд Зам, тээврийн яамнаас бас хавсралт 1.26.1.1 дээр байгаа авто тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгооны хамрагдалт суурь түвшин 50 хувь, ирэх жил 75 хувь гэж байгаа. Энэ нь арай бага тоо биш үү гээд өмнө нь 10 сард би хэлж байсан.

Тэгээд яг энэ чигээрээ дахиад ороод ирлээ л дээ.

Тэгээд нийслэлд нийтдээ 100 мянган техникийн үзлэгтэй хамрагдаагүй машинууд яваад байгаа. Эд нарыг яаж цэгцлэх вэ? Яамны зүгээс ямар бодлого байна?

**Р.Сэддорж:** С.Батболд дарга. 7 номер.

**С.Батболд:** Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Саяын төслүүд урт хугацааны “Алсын хараа-2050” болон бусад бодлогын баримт бичгүүдэд дурдагдсан эрэмбэлэхдээ бид хамгийн нэгдүгээрт хилийн боомтуудыг холбох.

Хоёрдугаарт нь, аймгуудын төвүүдийг хооронд нь холбох. Мөн үүнээс гадна бид олон улсын гэрээ конвенцод нэгдэн орохдоо бүс нутгийн болон олон улсын гэрээ конвенцод энэ замын нөхцөлийг сайжруулах, энэ замыг өргөжүүлэх гэсэн ийм одоо бодлогын чанартай төслүүдээ нэгдүгээрт эрэмбэлсэн байж байгаа. Мэдээж Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу бас эрэмбэлсэн байж байгаа.

Саяын таны хэлдэг бол техникийн хяналтын үзлэгтээ өмнө нь хэлж байсан. Үүнийг засах байх гэж бодож байна. Хуулиараа 100 хувь орох ёстой.

**Р.Сэддорж:** Эрчим хүчний яам. О.Хуягцогт дарга.

**О.Хуягцогт:** Асуултад нэмж хариулъя.

Эрчим хүчний салбарт эрчим хүчний зохицуулах хорооны энэ тусгай зөвшөөрөл эзэмшигч 110 гаруй аж ахуйн нэгж, байгууллага байгаа. Үүнээс 27 төрийн өмчит компани нь Эрчим хүчний сайдын багцад, Эрчим хүчний яам хувьцаа эзэмшигч Төрийн өмчийн хороотой хамтран хэрэгжүүлдэг.

Энэ компаниудын 2025 оны зорилтот түвшнийг батлах тэр орлого, зарлага урт, богино хугацаат зээл, энэ мөнгөн урсгалын эргэн төлөлтийг тооцож баталдаг. Жил бүр. Энэ бол 2025 оны 01 сарын эхний хагаст багтаж хийдэг юм.

Энэ ажил бол ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Дөнгөж сая үнэ тарифтай холбоотой зохицуулалтууд орсон учраас энэ дээр тооцоо судалгааг Эрчим хүчний зохицуулах хороо, яам, бусад байгууллагуудтай хамтран хийж байна.

**Р.Сэддорж:** Дараагийн гишүүн. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** 5 асуулт байна. Аудитын дүгнэлтэд Засгийн газарт өгөх зөвлөмж дээр байна л даа.

Бүсүүдэд, улсын хэмжээнд гээд. Тэгээд үүнийг тодорхой нэршилтэй болгож баталъя гээд.

Тэгээд би яах вэ өмнө нь ярьсан зүйлтэйгээ холбоотой зүйлээ л ярих гээд байна л даа. Энэ улсаас хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтуудыг аймаг, сумдад, орон нутагт, орон нутагтай хамтарч, олон улсын төсөл, хөтөлбөртэй хамтарч жийн үед илүү хурдан хугацаанд илүү үр дүнд хүрнэ.

Тэгээд үүнийг бүсүүдэд, улсын хэмжээнд гэсэн зүйлийг задлахад Байнгын хороодод танилцуулах уу, эсвэл Засгийн газар өөрөө задлах уу, эсвэл яам задалж батлах уу?

Улсын Их Хурлыг мэдээллээр хангаж энэ дээр ажиллаач гэдэг ийм саналтай байна. Энэ дээр ийм боломж байна уу? Үүнийг Хэрэг эрхлэх газар, Барилгын яам, Зам, тээврийн яам, Сангийн яам дөрвөөс асууж байна.

Хоёрт нь, хөрөнгө оруулалт дээр иргэд туннелтэй холбоотой асуудлыг их яриад байгаа л даа. Богд уулын туннелтэй холбоотой.

Тэгээд энэ зураг төсөв, ТЭЗҮ нь хийгдэж байгаа байх. Тодотголоор батлаад явсан.

Тэгээд үүнийг хувилбартай гаргаж байгаа юу, эсвэл зөвхөн яг нэг чиглэлээрээ л туннел барина гэдгээр гаргаж байгаа юу? Үүнийг иргэдэд их тодорхой мэдээлэл өгч явбал зүйтэй.

Яагаад гэвэл энэ туннелийг барихад чинь цахилгааны 3-аас доошгүй эх үүсвэр хэрэгтэй. Босоо чиглэлд агааржуулалтын олон хоолой гаргана гээд Монголд хэрэгжээгүй учраас нэлээн асуудалтай, олон он дамжиж хэрэгжих зүйл болно.

Энэ дээр ямар судалгаа тооцоо байгаа вэ? Яг үүнийг юу гэж үзэж байгаа вэ? Зам, тээврийн яамнаас.

Автобусны хувьд дунд оврын автобус нэвтрүүлэх боломжтой юу? Нийслэлд.

Тэгээд метротой адилхан автобусуудыг 5, 10 минутын зайтай явуулаад үзэх хувилбар ер нь байгаа юу? Энэ дээр холбогдох түгжрэл хариуцсан Үндэсний хороо, 20 минутын хотын сайд ямар судалгаа, тооцоололтой байгаа вэ?

Гуравдугаарт нь, хөнгөлөлттэй зээлийн хувьд би бол байнга л яриад байгаа. Үүнийгээ байнга ярина, шаардана. Энэ аялал жуулчлалын чиглэлээр хөнгөлөлттэй зээл уг нь энэ жил гаргах гэж байсан юм билээ. 2025 оноос.

Тэгээд үүнийг дахин өргөн мэдүүлэхдээ бүр хасчихсан юм шиг байна лээ. Уг нь энэ хамгийн зөв бодлого байгаа шүү дээ. Аялал жуулчлалын компани хувийн хэвшлүүд аялал жуулчлалын бизнесээ өргөжүүлье гэхээр ерөөсөө хөнгөлөлттэй зээл л олдохгүй байгаад байгаа юм. Өндөр хүүтэй зээл авахаар энэ бол бизнесээ явуулах боломжгүй болчихоод байгаа. Энэ дээр хариулт авъя.

Хэрвээ төсвийн байдал сайн байвал төсөв тодотгох уу? Сангийн сайдаас үүнийг бас асууя.

Яагаад гэвэл бид бас өөдрөг энэ зүйл дээр төлөвлөлтөө хийх ёстой. Хэрвээ тодотговол энэ дэд бүтцийн одоо энэ 10 төсөл хасагдахаар, хойшлуулахаар орж ирсэн. Энэ эхний ээлжид эрэмбэлэгдэх үү? Үүнийг бас асууя.

Сонгуулийн амлалттай холбоотой зүйл дээр Ерөнхийлөгчийн хоригт тодорхой 3 зүйлийн нэг нь дурдсан. Энэ зүйл дээр ямар байр суурьтай байх вэ?

**Р.Сэддорж:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Жилийн дундуур төсөвт тодотгол хийх, үүсэх нөхцөл нь өөрөө хуульд заасан байдаг. Эдгээр нөхцөлүүд үүсэх эсэхийг одоо тодорхойлж мэдэхгүй учраас тодотголын талаар одоо ярихад бол эрт. Тэгэхдээ ер нь бол аль болох нэгэнт төсвөө батлагдаад авбал тодотгол хийхгүй байхад л хичээнэ дээ.

Мөнгөний бодлогоос ярьж байгаа. Энэ гишүүдийн ярьж байгаа нэлээн болгоомжтой эрсдэл талаас нь харж ярьж байгааг бодвол мөнгөний бодлоготойгоо хэрвээ нийцүүлье гэдэг талаас нь харах юм бол орлого давсан хэмжээгээр мөнгөний нийлүүлэлтийг тэр хэмжээгээр багасгана гэсэн үг.

Тэр хэмжээгээр өөрөөр хэлбэл төсөв дотроо хумиад төсвийнхөө тэнцлийг сайжруулаад явах ийм чиглэл рүү.

Хөрөнгө оруулалт нэмэх боломж төсвөөс гадуур. Бид нарын яриад байгаа тэр эрх зүйн боломжууд нь нэмэгдээд, Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль, мөн Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, бусад баялгийн солилцооны эрх зүйн боломжууд нээгдэх аваас тэрийг дагаж бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөгөөнд тусгагдсан олон мега төслүүдийг санхүүжүүлэх, урагшлуулах, хөдөлгөх ийм зүйлүүд гарахыг үгүйсгэхгүй. Тийм.

Төсвийн тодотголын хувьд одоо ярихад хараахан эрт байна.

**Р.Сэддорж:** Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас. Ж.Болормаа Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. 7 номер.

**Ж.Болормаа:** Асуултад хариулъя.

Монголд зочлох жилтэй холбогдуулаад аялал жуулчлалын дэд бүтцийн асуудлыг сайжруулах асуудал нэлээдгүй хөндөгдөөд. Энэ дээр 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлийн асуудал хэрэгжээд улам явсан.

Одоогийн байдлаар 30 тэрбум орчим төгрөгийн зээлийн асуудал гарчихсан. Энэ нь өөрөө аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгож байгаа зам дагуух үйлчилгээний цогцолборуудыг бий болгож байгаа.

Мөн зочид буудал, жуулчны баазууд дээр ногоон буюу эко технологиудыг нэвтрүүлж байгаа жуулчны баазуудад нэлээдгүй үр дүнгээ өгч байгааг зээл гэж уг нь харсан.



Гэхдээ яг нөгөө бүтэн байдлаар хасагдах нь бас яг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд нэлээдгүй жоохон сөрөг гэх юм уу нөлөөтэй байгаа.

Тэгэхээр магадгүй үүнийг дэмжээд явах нь суурь асуудлаа шийдвэрлэх, яг аялал жуулчлалын зочлох.../минут дуусав/

**Р.Сэддорж:** М.Бадамсүрэн гишүүн. Гүйцээгээд хариулчих. 7 номер.

**Ж.Болормаа:** Ер нь Монгол зочлох жилийн эхний гол зорилтууд эрх зүйн орчин бүрдүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх асуудлууд байсан.

Хууль, эрх зүйн шинэчлэлүүд хийгдээд ерөнхий суурь асуудлууд тавигдсан. Одоо хоёр дахь шатын асуудал буюу аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах асуудал руу ингээд 2025 оноос ороод явж байгаа.

Тэгэхээр энэ дээр энэ зээлийн дэмжлэгийн асуудал аж ахуйн нэгжүүд дээр нэлээдгүй дэм болохоор харагдаж байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг дэмжээд явах нь зүйтэй байх гэж харж байгаа.

**Р.Сэддорж:** Ж.Батсуурь сайд хариулъя.

**Ж.Батсуурь:** Бүсийн хөгжлийг дэмжих гэж. Манай дээр бол бүсийн хөгжлийг дэмжих шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэх бүсүүд гээд 213 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй.

Тэгээд энэ сая буураад 52 тэрбум төгрөг тавигдсан. Их Хурлын чуулган дээр бас зарим орон нутгийн төлөөлөл, орон нутагтайгаа хосолж хийвэл бас боломжтой юм биш үү гэсэн саналууд гарч байсан.

Гэхдээ үүнийг тавихдаа зүгээр нэг таагаад тавьчхаагүй. Сангийн яамтайгаа ярьж шалгууруудыг хангасан сум, суурин газруудынхаа дэд бүтцийг шийдье гэсэн байдалтайгаар тавьсан байгаа.

Төвийн бүс, баруун бүс гээд бас яригдсан. Нэгдүгээрт, зураг төсвийн асуудлууд бүрэн хийгдсэн байх ёстой, магадлалаар орсон байх ёстой. Мөн орон нутгаасаа тодорхой хэмжээний дэмжлэгүүд авсан байх ёстой гэсэн зүйлүүдийг яригдаж байгаа.

Тэгээд энэ бол заавал.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ж.Батсуурь сайд гүйцээж хариулъя.

**Ж.Батсуурь:** Засгаар ороод байх шаардлагагүйгээр Сангийн яамтайгаа бид ярьж байгаад нөхцөл байдлыг.

Мэдээж энэ их хүсэлт бол одоо 213 тэрбум биш, бараг энэ чинь их наядын хүсэлт байж байгаа.

Тэгээд ирэх онд тавигдаж байгаа нь 52-хон тэрбум төгрөг. Энэ чинь сум, аймгуудад хуваахаар маш бага мөнгө. Дэд бүтцэд асар их том хөрөнгө оруулалт шаарддаг учраас.

Тийм учраас аль болох он дамжихгүй, унжруулж санжруулахгүй, хамгийн эдийн засгийн үр ашигтай хүн амд шууд үр дүн нь хүрэхүйц ийм хөрөнгө оруулалтуудыг хамтдаа хийнэ гэж байгаа. Заавал засгаар орно гэсэн шаардлага байхгүй гэж үзэж байгаа.

**Р.Сэддорж:** Зам, тээврийн яам. С.Батболд дарга. 7 номер.

**С.Батболд:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд.

Дэд бүтцийн хөрөнгө оруулалт дээр бид зөвхөн улсын төсвөөс гадна олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай ярьж байгаа ийм хөрөнгө оруулалтууд нэлээн байгаа.

Түрүүн бид жишээ нь эрэмбэлэх асуудал дээр хэлсэн. Карикийн хүрээ 4-Си коридорыг бид дэмжлэг үзүүлье гэдэг ийм санал гаргаад Улаанбаатараас Багануур хүртэлх замыг 4 эгнээ болгох асуудлыг Азийн хөгжлийн банк жишээ нь дэмжиж болж байна. Гэх мэтчилэн ийм асуудлуудаар бид ярилцаж байна.

Тэгээд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Европын сэргээн босголт банкнуудтай ийм хөрөнгө оруулалтуудыг ярихын зэрэгцээ хувийн хэвшлүүдийн хөрөнгө оруулалтыг бид бас ярьж удахгүй зарлах гэж байна. Жишээ нь Замын-Үүдээс Хөшигийн хөндий хүртэлх энэ замыг 4 эгнээ болгох замыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх гэх мэтчилэн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Тодруулга авах юм байна. 1 минут. М.Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Би зарим зүйл дээр тодорхой хариулт авч чадсангүй. Алдагдалгүй баталж байгаа тохиолдол бараг анхных гэж байгаа.

Тэгэхээр яах вэ өөдрөгөөр хараад, тэгээд ийм нэмэх тодотгол хийх үү гэж л асуугаад байгаа юм л даа. Ийм нөхцөл ер нь бараг л үүсэх байх л гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр бэлтгэлтэй байх боломжтой юу гэж асууж байгаа юм.

Хоёрдугаарт нь, аудитын дүгнэлтээс л би асууж байгаа юм. Энэ дэд бүтэц, шалгуур үзүүлэлт гээд.

Ямар нэгэн сайдын лоббигоор, эсвэл нөлөө бүхий олонд сонгогдсон улс төрчийн лоббигоор энэ бүсүүдэд гэж байгаа, улсын хэмжээнд гэж байгаа хөрөнгө оруулалтыг битгий тавиасай л гэж би чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Өмнө нь ийм гашуун түүх байгаа шүү. Ховд аймагт бүх сум нь бараг засмалаар холбогдсон. Гэтэл зүүн бүсэд боомтууд нь холбогдоогүй, өмнөд бүсэд холбогдоогүй, хойд бүсэд холбогдоогүй.

Тэгэхээр энэ эдийн засгийн үр өгөөжөө өгдөг зүйл дээр яаж зарцуулах юм бэ?

Тэгээд дараагийнх нь туннелтэй холбоод би хариултаа авч чадсангүй. Энэ их олон нийтэд тодорхой ойлголт бас өгмөөр байна. Туннел.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер. 5 номер. Б.Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулья.

Одоо тодотгол хийнэ гэж ямар нэг тийм ам гармааргүй байна. Таны өөдрөг төсөөлж байгаад талархлаа. Талархалтай хандаж байна.

Ирэх жил бидний төлөвлөж байсан эдийн засгийн өсөлтөөсөө давж биелбэл их л сайн байна. Нөгөө талдаа биднээс шалтгаалаагүй гадаад нөхцөл байдал, энэ геополитикийн асуудлуудаас болоод манай гол түүхий эдүүд дээр эрсдэл биет хэмжээгээр ч тэр, үнийн хувьд ч тэр эрсдэл гарч болзошгүй гэдэг ийм үндэслэлүүдээр. Макро агрегатууд гэсэн үг шүү дээ. Ийм үндэслэлүүдээр хориг тавиад цаашдаа алдагдалгүй явъя гэдэг ийм формат руу бодлогын шилжилт хийе гэдэг ийм чиглэл авсан.

Ийм төлөвлөлтөө хийгээд төсвөө өргөн барилаа. Зүгээр хойтон хэрвээ орлого давбал тодотгол хийнэ гэдэг тийм тодотголын урьдчилсан нөхцөл байдаггүй юм. М.Бадамсүрэн гишүүн ээ. Та үүнийг бас гадарлах байх.

Ер нь төсөв дутвал дандаа тодотгол хийнэ гэсэн л ийм зохицуулалт байдаг юм. 5 шаардлага нь.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Н.Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Тодотгол хийвэл гэсэн төсөөлөл ч юу байх вэ дээ. Тодотгол хийнэ гэж тогтоол гаргаж байгаад л бид чинь өөрсдөө ийм байдалд орчихсон шүү дээ. Сангийн сайд аа. Бодит амьдрал бол. Өөрсдөө тогтоол гаргачихсан хүмүүс.

Тодотгол хийж хийвэл ер нь хэмнэх тодотгол хийх юм уу, үр ашигтай

тодотгол хийх юм уу гэдгийг л гишүүд асуугаад байгаа юм. Үүнийг дахиад нэг нэмээд асуучихъя.

Хоёр дахь нь, Сангийн сайдаас. Улаанбаатар хоттой холбоотой том төслүүд аль нь явж, аль нь үлдэх гэж байна. Үүнийг нэг Улаанбаатарчуудад нэг тодорхой хэлж өгөөч ээ.

Гурав дахь нь, Дархан, Алтанбулаг хүртэлх 4 инээ замыг үлдээж болсонгүй юу? Энэ уг нь их том бодлогын. Бидний нөгөө яриад байгаа бүсчилсэн хөгжлийн, улс орны эдийн засгийн хөгжлийн том асуудал байсан. Үүнийг үлдээж болсонгүй юу гэдэг нэг асуулт байна.

Эдийн засаг, хөгжлийн сайдаас асууя. Олон нийт анхаарал тавиад байна. Энэ Евро-Азийн эдийн засгийн чөлөөт хэлэлцээр гээд нэг юм яригдаад байгаа юм.

Энэ ер нь чухам ямар учиртай юм, юу болоод байна аа? Байнгын хороон дээр албан ёсны байр суурь Эдийн засгийн сайд илэрхийлээч ээ.

Сангийн яам хариулах юм бол уу, яах юм бол. Их Хурлын гишүүн мэдэгдэл гаргасан байна. Эрчим хүчний үндэсний хороо зөвхөн хэвлэл мэдээлэлд зориулж 8 тэрбум төгрөгийн зардал тавьсан байна гээд.

Тэгээд одоо бид хэмнэх гээд байгаа юм уу, тансаглах гээд байгаа юм уу? Нэг Үндэсний хороо 8 тэрбумаар хэвлэлийн сурталчилгаа хийдэг. Үүнийг хариулж өгөөч.

**Р.Сэддорж:** Хариулт 5 номер. Сангийн сайд Б.Жавхлан.

**Б.Жавхлан:** Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Түрүүн М.Бадамсүрэн гишүүний асуулттай ойролцоо. Төсөв үр ашигтай байна гээд тодотгол хийдэггүй. Өөрөөр хэлбэл орлого нэмж биелбэл түүнд тааруулсан хөрөнгө оруулалт гэдэг юм уу, урсгал зардал тавиад баланслуулдаг ч юм уу, тийм тодотголын хуулийн нөхцөл одоо байгаа төсвийн хууль дээр байхгүй.

Харин орлого дутаад, орлого тасраад, үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд санхүүжүүлэх боломжгүй болж ирвэл зардлаа танах ийм л тодотгол хийгддэг байгаа.

Тэгээд ирэх жил гүйцэтгэл яаж явахыг урьдчилж хэлж мэдэхгүй байна.

Ер нь бидний тооцоолж байснаар нэлээдгүй танаж орж байгаа учраас гүйцэтгэл би хэвийн гарах болов уу л гэсэн ийм шинэ төсөөлөлтэй болж ирж байгаа.

Улаанбаатарчууддаа хандаж хэлэхэд Улаанбаатар хотын одоо орон нутгийн

өөрийнх нь төсөв дээрээс санхүүжих дүнд ямар ч өөрчлөлт орохгүй. Ямар ч өөрчлөлт орохгүй. Ялангуяа томоохон хөрөнгө оруулалтууд дээр ямар ч өөрчлөлт орохгүй. Засгийн газар дээрээс баримталж байгаа бодлого бол ерөөсөө Улаанбаатар нийслэлийн түгжрэл ирэх оны төсөв дээр бол номер нэг асуудал болчихоод байгаа шүү.

Тийм учраас Улаанбаатарчууд төлөвлөсөн хийгдэж байгаа ажлууд дээрээ ямар ч эргэлзээгүй ийм хүлээлттэй байх хэрэгтэй.

Дархан, Алтанбулагийн зам. Тийм ээ. Харамсалтай. Энэ бол одоо манай тойргийн зам бол биш шүү.

Энэ бол Монгол Улсын одоо хойд хоймор, үүд ийм том зам. Энэ Евро-Азийг холбосон Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр явдаг энэ магистралын хамгийн өндөр ачаалалтай хэсэг нь.

Яах вэ, тэгэхдээ нэг удаа бид ингээд төсөв, хөрөнгө оруулалт дээрээ тэвчиж болох, хойшлуулж болох төслүүдээ зохицуулалт хийе гэж байгаа учраас тэнд өнөөдөр замгүй байгаа биш зам бол байж байгаа. Түгжрэл үүсээд гацчихсан зүйл байхгүй.

Энэ жил гэхэд л хэдэн тэрбум билээ дээ. Засвар, сайжруулалт хийгдээд явж байгаа.

Бид төсөв дээрээсээ л хөрөнгө оруулалтаа хойшлуулж байгаа боловч төр, хувийн хэвшлийн түншлэл ч юм уу, өөр ямар нэг хэлбэрээр үүнийг санхүүжүүлэх эх үүсвэрүүдээр хайж ажиллана. Болохгүй бол 2026 оны төсөв дээрээс төсвийн байдлаа харж байгаад эргүүлж тавих ч юм уу ийм бодлогууд бидний өмнө дараагийн сорилт болж байна.

Тэгээд тантай санал нийлж байна. Энэ бол бас нэлээн харамсалтай зүйл болж байгаа.

Эрчим хүчний сүм байна уу? Эрчим хүчний үндэсний хорооноос. О.Хуягцогт дарга хариул даа.

Ер нь Эрчим хүчний үндэсний хороон дээрээс Засгийн газарт ийм хүсэлт ирээд, тэгээд бас тодорхой хэмжээнд бусад салбаруудтай ижилхэн танагдаад тавигдсан байгаа. Юу, юунд зарцуулахыг Эрчим хүчний хорооноос саналаа тайлбарлах нь зөв байх.

**Р.Сэддорж:** 7 номер. О.Хуягцогт дарга.

**О.Хуягцогт:** Гишүүний асуултад хариуля.

Эрчим хүчний сайдын багц дээр саяын таны асуултад хэлсэн зориулалтаар нэг ч төгрөг тавигдаагүй.

Анх өргөн барьсан төсөл дээр Эрчим хүчний сайдын багцад эрчим хүчний үндэсний хорооны төсөв байхгүй.

**Р.Сэддорж:** Б.Жавхлан сайд үргэлжлүүлж хариулъя.

**Б.Жавхлан:** Эрчим хүчний үндэсний хороон дээр Т.Доржханд Шадар сайд ахалдаг. Эрчим хүчний сайд өөрөө ордог. Бусад өөр Төрийн нарийн ч ордоггүй байх. Нэлээн албан тушаалтнууд ордоггүй байгаа шүү.

Тэндээс ирсэн санал. Өөрөөр хэлбэл үндэсний хороодд дээр тодорхой хэмжээний үйл ажиллагааг нь дэмжлэг болгож төсвүүд тавигддаг. Энэ жишгээр Эрчим хүчний үндэсний хорооны хувьд энэ жилийн 3, 4 дүгээр улирал, дараа жилийн ер нь эхний 1, 2, 3 дугаар улиралд хүртэл нэлээн өндөр ачаалалтай.

Энэ дээр нийгэмд зөв ойлгуулах, бусад өөр ажлуудын шаардлагаар хүсэлт ирсэн.

Ингээд үүнийг Засгийн газар дээр яригдаад бусад үндэсний хороод болон төсвийн ерөнхийлөн захирагч нарын жишгээр ирсэн хүсэлтээс нь 10 хувь байх аа. Тийм. 10 хувь мөн хасагдаад тусгагдсан байгаа. Тэр дотор нь хэвлэлийн зардлууд байгаа. Хэвлэл мэдээлэлд зориулах зардлууд байгаа.

**Р.Сэддорж:** Л.Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Эрхэм гишүүний асуултад хариулъя. Евро-Азийн хэлэлцээр сүүлийн 2 жил гарангийн хугацаанд явагдаж байгаа юм билээ. 4, 5 удаагийн уулзалт яваад хоёр талдаа татварын хөнгөлөлтийг ямар бараан дээр хийх вэ гэдэг ийм хэлэлцээр.

Ер нь өчигдөр тав дахь өдрөөс эхлээд шинээр юм гараад ирсэн юм шигээр, гэнэт харсан юм шигээр. Мэдээж дотоодын үйлдвэрлэгчид өөрийнхөө санаа бодлыг хэлэх нь бол туйлын зөв гэж би хувьдаа бодож байгаа.

Тэгэхдээ үүнийг шинэ сонссон юм шигээр ингэж айхтар ярьж байгаа нь жоохон эмзэглэж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан баг маргааш уу. Тийм ээ. Хэвлэлийн бага хурал хийж яг ямар процесс сүүлийн он жилүүдэд юу болсон бэ, өнөөдөр ямар түвшинд байгаа вэ гэдэг ийм дэлгэрэнгүй мэдээллийг хийнэ.

Байнгын хороон дээр ч гэсэн дэлгэрэнгүй мэдээлэл хийнэ.

**Р.Сэддорж:** 2 номерын микрофоныг нээе. Өөрийгөө танилцуулаарай.

**И.Батхүү:** Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Евро-Азийн эдийн засгийн холбоонд элсэх гэдэг асуудал сүүлийн үед сошиалаар бас үүнтэй холбож их мушгиж тайлбарлаад байгаа.

Нэгдүгээрт, ийм асуудал байхгүй ээ гэдгийг албан ёсоор мэдэгдье.

Энэ Евро-Азийн эдийн засгийн холбооны гаалийн нэгдсэн тогтолцоотой 5 улс тусдаа бие дааж хэлэлцээр хийх боломжгүй учраас холбоотой нь Монгол Улс энэ хэлэлцээрийг хийж байгаа.

Чөлөөт худалдааны түр хэлэлцээр.

Евро-Азийн эдийн засгийн холбоо нь өөрөө Сингапур, Вьетнам зэрэг зэрэг худалдааны туршлагатай туршлагатай улсуудтай ч гэсэн яг ийм хэлэлцээр хийчихсэн байдаг.

Тэгэхээр энэ дээр нэг мөсөн эргэлзээгүйгээр ойлгож болно.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын зүгээс өнгөрсөн хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн хамааралтай биш төрөлжсөн эдийн засгийн бүтэцтэй болох асуудлыг бараг бүх л эдийн засагч нар ярьж ирсэн. Үүнийг хэрэгжүүлэх гол арга зам нь экспортын зах зээлийг тэлэх, экспортын зах зээлээ дагаад хөрөнгө оруулалт нэмэгдэх.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 2 номер гүйцээгээд хариулчих уу? 1 минут.

**И.Батхүү:** Экспортын зах зээл тэлсэний дараа хөрөнгө оруулалт уурхайн бус салбарт орж ирээд манай Монголын экспортод гаргах боломжтой, боловсруулах боломжтой бүтээгдэхүүний нэр төрөл, өрсөлдөх чадвар сайжрах тийм үр дагавар гарна.

Яг одоо сошиал дээр яваад байгаа шиг 2 мянган төрлийн барааг татвараас чөлөөлж байгаа юм байхгүй. Яг одоо Монголын талаас 633 бараа, Евро-Азийн эдийн засгийн холбоо талаас 511 төрлийн бараа харилцан татварын чөлөөлөлттэй орж ирэх боломжтой.

Энэ бараанаас гадна бас хоёр талын хооронд хийх худалдааг хөнгөвчлөх маш их олон асуудал энэ хэлэлцээрээр зохицуулагдаж байгаа юм. Чөлөөт худалдааны түр хэлэлцээрээр.

Экспортод гаргах гэж маш их зовлон тоочдог. Хилээр гарангуут ийм ийм саад бэрхшээл гарч байна. Ийм ийм хүндрэл байна. Ийм ийм квот, тарифын бус

арга замаар хааж байна гээд. Энэ асуудлуудыг бүгдийг нь шийдвэрлэе гэсэн зорилготой энэ хэлэлцээрийг явуулж байгаа.

Бас өнгөрсөн хугацаанд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Н.Батсүмбэрэл гишүүн тодруулга. 1 минут.

**Н.Батсүмбэрэл:** Энэ асуудлаар тодорхой хариулт өгсөн Л.Гантөмөр сайд болон Эдийн засаг, хөгжлийн яаманд баярлалаа.

Тэр 8 тэрбумын асуудлыг нэг тодорхой хариулчихмаар байх юм. Тэр Эрчим хүчний яам уу, Эрчим хүчний зохицуулах хороо юу нэг хүн асуудлаа ойлгоогүй явж байх юм.

8 сая төгрөг, 800 сая төгрөг биш, 8 тэрбум төгрөгийг хэвлэл мэдээлэлд зарна гээд оруулчихсан байна. Энэ үнэн үү?

Улсын Их Хурлын гишүүн албан ёсны мэдэгдэл хийсэн байна. Гишүүн худлаа хэлсэн үү? Нөгөө хянан шалгаж байгаа аудит нүдээ боочихсон уу?

**Р.Сэддорж:** Хариулт. Эрчим хүчний яам. 7 номер.

**О.Хуягцогт:** Гишүүний асуултад Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт.

Миний хариулт бол Эрчим хүчний сайдын багцад энэ зориулалтаар огт төсөвт тусгагдаагүй гэдгийг хариулсан.

Б.Жавхлан сайд түрүүн энэ мэдээллээр энэ бол. Хариулт дууслаа.

**Р.Сэддорж:** Тодруулж хариулах уу? Б.Жавхлан сайд. Та 1 минут микрофон аваад хэлчих үү? Б.Жавхлан сайдын микрофоныг нээе.

**Б.Жавхлан:** Үгүй ээ, энэ тэгэхдээ яах вэ бас заавал Шадар сайд руу гээд байх юм байхгүй. Энэ чинь манай Засгийн газрын л бодлогын асуудал. Бид кабинетын зарчмаараа л явж байгаа ийм зүйл.

Төсөв дээр суусан төсвийн зардал ч бай, хөрөнгө оруулалт ч бай бүхий л юман дээр бүгдээрээ л энэ шийдвэрүүдээ тайлбарлаад л ингээд л явна.

Үндэсний хорооны хувьд энэ жил шинээр байгуулагдсан. Намар, ирэх жил ер нь манай хийж байгаа том реформуудын нэг ажил бол яг л энэ л болно шүү дээ.

Тэгээд энэ 8, 9 тэрбум төгрөг хэвлэлийн зардлаа гаргах уу, эсвэл энэ реформоо хийж чадахгүй буцах уу? Энэ бол өөрөө зардал нь, алдах боломж нь хэдэн их наядаар яригдана.



Тийм учраас үүнийг ойлгуулах, хэвлэл мэдээллээр дамжуулж олон нийтэд одоо үүнийг зөв ойлгуулах. Тэгж байж энэ реформ хийгдэнэ шүү дээ. Аливаа реформ бол нийгмийн дэмжлэггүйгээр хэн ч зүтгээд, ямар ч том улс төрч гарч ирээд хийж чадахгүй.

Тийм учраас эхний сорилт нь олон нийт үүнийг хүлээн зөвшөөрч зөв ойлгох энэ л чухал асуудал.

**Р.Сэддорж:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Би гуравхан асуулт асуучихъя. Гялс асуучихна.

Өчигдөр бид Монголбанкныхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнтэй уулзсан.

Нөхдүүд юу ярьсан бэ гэхээр төсвийн энэ хэт тэлэлтийг Монгол Улсын эдийн засаг шингээж чадахгүй гэдэг байр суурьтай байгаагаа одоо бид нарт илэрхийлж байна лээ.

Үүнийгээ та бүгд Сангийн яамтайгаа ярьсан юм уу? Сангийн яам энэ нөхдүүдийн дүгнэлтийг авч үзсэн юм уу? Эсвэл тоогоогүй юм уу? Ямар ч байсан энэ хоёр том байгууллагаас төсвийн сүүлийн 2 жилийн энэ том тэлэлт чинь эдийн засаг шингээж чадахгүй шүү гэдэг тийм саналыг өчигдөр өгсөн юм. Үүнийг би Сангийн сайдаас нэг л асуучихъя.

Хоёрт нь, сая бид Монгол Улсын амин чухал газрын тосны үйлдвэрийнхээ санхүүжилтээс 200 орчим тэрбумыг танаж байна. Энэ яагаад танахаар болов? Энэ үйлдвэр хэзээ ашиглалтад орох юм бол? Ер нь энэ чинь таначих юм бол бараг дахиад хэдэн жил хойшлох бол бид. Дандаа хойд хөршөөсөө бензинээ гуйж амьдарсаараа байх уу? Хоёр дахь ийм асуулт байна. Энд хариулж өгөөч ээ гэж.

Гуравт нь, манай Байнгын хороонд хамаагүй мөртдөө би аудитаас нэг юм асуучихъя.

Энэ төсөв өргөн барихад Удирдлагын академийн зардал гээд 6.1 тэрбум төгрөг орж ирсэн. Аудит энэ дээр ажилласан уу? Энэ Удирдлагын академи гэж нэг харахад улсын байгууллага шиг, нэг харахад их дээд сургууль шиг. Нэг гараараа улсын төсвөөс хөрөнгө авдаг. Нөгөө гараараа оюутнуудаасаа төлбөр авдаг. Ийм сонин статустай байгууллага байна. Үүний статусыг та хэд аудитын байгууллага эргэж харах асуудлыг дүгнэлтдээ яагаад оруулж ирсэнгүй вэ?

Ер нь Удирдлагын академийн асуудлыг энэ Засгийн газар ярихгүй бол нэг ийм нэр нь хүртэл ийм даргын академи гэсэн тийм нэртэй. Дарга бэлдэх. Тэгээд баахан улсууд шоуддаг ийм газар болчихсон байгаа. Энэ байгууллагынхаа асуудлыг Үндэсний аудитын газар санал энэ тэртээ яагаад оруулж ирсэнгүй вэ?

Энэ байгууллага ер нь заавал улсаас хөрөнгө авч явах ямар шаардлага байгаа юм бэ? Бусад сургуулиуд бүгдээрээ улсаас хөрөнгө авахгүй өөрийнхөө сургалтын төлбөрөөр амьдраад болж байгаа шүү дээ.

Тэгээд энд хариулж өгөөч.

**Р.Сэддорж:** Сангийн сайд хариулах уу? 5 номер. Сангийн сайд.

**Б.Жавхлан:** Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулья.

Хоёр асуулт бол үндсэндээ холбоотой хоёр асуулт. Нефть боловсруулах үйлдвэр энэ жилийн өргөн барьсан төсвийн мөн чанар гэсэн үг. Маш том төлөвлөгөө, хөтөлбөрөө бид батлуулсан. Том зорилт тавьсан.

Эхний бүтээн байгуулалтын жил бүтэн жил 2025 он байх болно.

Тийм ч учраас 9 сард тодотголын үеэр маргалдаад байдаг нэг асуудал чинь энэ шүү дээ. Бид баахан гадаад зээл батлуулчихсан байдаг. Ашиглаж чаддаггүй. Нөгөө төслүүд нь бүгд дуусдаггүй.

Ингээд л нэг сэглэж сэглэж хөрөнгө оруулалтуудыг нь тавьсаар байгаад л ингээд өнөөдрийг хүртэл сунжраад яваад ирчихсэн. Нефть боловсруулах үйлдвэр жишээ нь ирэх жил бид 1 их наяд төгрөгийн санхүүжилт хүсэж байгаа. Авсан зээлээсээ, авч байгаа зээлээсээ 1 их наядыг санхүүжилтэд тавиад өгөөч ээ гээд.

Гэтэл манай энэ төсвийн дүрэм хязгаарлалтууд маань ийм боломж олгохгүй байгаа.

Сая бид тотгол хийх үеэр энэ боломжоо нэг жоохон нэмж авсан. 1.2 их наядаар нийт санхүүжилт явдаг байсан бол 2.2 арайхийж болгож авсан. Үүнийгээ эргүүлээд явж байгаа 108 төсөлд хуваарилна 108 төсөлд.

Энэ дотроос хамгийн том нь нефть боловсруулах үйлдвэр байгаа. Дараагийнх нь Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламж гэх мэт. Дараа нь Мянганы сорилын сангийн мөн дараагийн усан хангамжийн төсөл гээд. Гэх мэт том төслүүд нь энэ юм байгаа юм.

Ингээд энэ чинь ерөөсөө төсвийн тэлэлтийн хамгийн том тоо нь ерөөсөө энэ дотор явж байгаа. Тэгээд ингэж тэлж болохгүй ээ. Алдагдалгүй төсөв батална. Энэ төсвийн тэлэлт нь хэт өндөр байна гээд ийм шийдвэр гарчихаар одоо мэдээж хамгийн том тэлснээсээ л хасагдаж таарна.

Тэгэхээр хамгийн түрүүнд өртөж байгаа маань энэ хэсэг нь.

Тэгээд ирэх жилийн санхүүжих дүнг гадаад зээлийн ашиглалт учраас Засгийн газар дотроо нааш нь цааш нь зохицуулалтууд хийгээд аль болох нефть боловсруулах үйлдвэр дээрээ одоо байгаа дүн дотроосоо аль болох түлхүү тавихыг л бодно.

Гэхдээ 2026 онд ашиглалтад орох энэ цаг хугацааны хувьд бас эрсдэлд орно. Тодорхой хэмжээний эрсдэлд орно.

Тэгэхээр энэ дээр бид шинэ зохицуулалт, өөр боломжууд юу байх нь вэ эрэлхийлнэ.

Ингээд мөнгөний бодлоготойгоо уяж харъя. Мөнгөний бодлогыг буруушаах юм байхгүй. Мөнгөний бодлогын хуулиар нэгдүгээр үүрэг нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах чадварыг хамгаалах. Өөрөөр хэлбэл инфляц. Бодлогын номер нэг зорилт нь.

Засгийн газрын хувьд хөгжлийн том зорилтуудаа биелүүлэх л үндсэн зорилттой. Сангийн яам төсвийн бодлого үүнийгээ санхүүжүүлэх үндсэн үүрэгтэй.

Тэгэхээр Засгийн газар аль болох хөгжлийнхөө зорилтуудыг хангаад явна. Мөнгөний бодлогын орчинд нь аливаа эрсдэл үүсэх юм бол Монголбанк өөрсдийнхөө бодлогын хэрэгслээрээ бие даасан бодлоготой үүгээрээ зохицуулалтаа хийгээд явна.

Ирэх жилийн хөгжлийн дотоодын нийт бүтээгдэхүүни өсөлт маань 8 хувь. Энэ жил бид 9 сарын 01-нд өргөн барьсан. Сарын дараа манай төсвийг судалж үзээд Монголбанкнаас өргөн барьсан инфляцын түвшин бол энэ жилийнхээсээ бууруулж тавьсан шүү. 6-г 5 болгосон. 5 болгосон.

Тэгэхээр энэ мөнгөний бодлоготой бол айхтар хол зөрсөн гэж бид харахгүй байгаа.

Одоо харин шинэ нөхцөл байдал, ер нь гадаад нөхцөл байдал, геополитикийн асуудал энэ сараар биш өдөр өдрөөр өөрчлөгдөж байгаа ийм орчинд ирэх жилүүдэд нэлээн тоормостой явъя. Хөгжлийнхөө зорилтуудаасаа ухрахгүй, зөвхөн төсөв дээрээ авах ачааллаа багасгая.

Төсвөөс гадна өөр хөгжлийн санхүүжилтүүдийг хийх өөр ямар боломжууд байна. Эрх зүйн хувьд ч тэр, биет хэмжээгээр ч үүнийгээ нэлээн либерал болгох тал дээрээ түлхүү анхаараад явъя гэдэг л ийм л бодлогын шилжилт хийж байгаа гэсэн үг. Тийм.

**Р.Сэддорж:** Аудит 3 номер.

**Я.Самбууням:** Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулья.

Удирдлагын академи нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайдын багцад хамаардаг байгууллага юм билээ. Төрийн албан хаагчдын тасралтгүй боловсролыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Энэ жилийн төсөв дээр тавигдсан 6 тэрбум нь урсгал зардал болон шинэ барилга баригдаж байгаагийнх нь хөрөнгө оруулалтын зардал тавигдсан гээд чуулган дээр Н.Учрал сайд тодорхой хариулт өгч байсан.

Мөн бид 2024 оных нь санхүүгийн тайлангийн аудитыг хийж явж байна.

Энэ дээр Удирдлагын академийн хөрөнгийн зарцуулалттай холбогдуулсан иргэдээс ирсэн санал, гомдлыг аудитад хамруулаад явж байна. Үр дүн нь хараахан гараагүй байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Ж.Алдаржавхлан гишүүн тодруулга авах уу? Ж.Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Аудитын дарга аа, миний юуг ойлгосонгүй. Тэр статусыг нь өөрчлөөч ээ гээд байна шүү дээ.

Ямар байгууллага нь нэг харахад Засгийн газрын агентлаг, нөгөө талаас нь харахад сургууль. Ямар байгууллага нь нэг гараараа төсвөөс хөрөнгө аваад, нэг гараараа хүнээс төлбөр авдаг юм бэ?

Энэ байгууллагын статусын асуудлыг өөрчлөх асуудлыг аудитын байгууллага оруулж ирээч ээ. Би одоо энэ төсвийн хуралдаан дээр зарчмын зөрүүтэй санал гаргана шүү. Тэр Удирдлагын академид зардал, санхүүжилтийг хасах саналыг би төсвийн ажлын хэсэг дээр гаргана. Та бүгд харин тэрийгээ хэлж өгөөрэй.

Энэ угаасаа утгагүй. Удирдлагын академид сураад ийм гавьяа байгууллаа гэдэг хүн Монгол Улсад өнөөдөр байхгүй. Зүгээр хэсэг бүлэг хүн тэнд нийлж архидаж шоуддаг газар болчихсон. Бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Үүнийг.

Энэ байгууллагыг статусыг нь өөрчлөх ёстой. Сургууль бол сургуулиар явах ёстой. Засгийн газрын агентлагаар агентлагаар явж төсвөөсөө санхүүжилт авах ёстой.

Үүнийг та нар аудитын байгууллага дэмжиж өгөөрэй. Би энэ асуудлыг одоо энэ төсвийн хэлэлцүүлгээр оруулж ирнэ шүү. Үүнийг хэлэх гэсэн юм.

**Р.Сэддорж:** Санал уу? Аудит хэлэх үү? Аудит 3 номер.

**Я.Самбууням:** Яг аудитын байгууллага бол энэ байгууллагуудын статусыг тодорхойлох чиг үүрэг байхгүй. Энэ бол яг Засгийн газрын өөрийнх нь статусыг нь тодорхойлох асуудал байх гэж бодож байна.

Бид аудитынхаа явцад яах вэ, энэ дээр үнэхээр яг хоёр талаас санхүүжилт аваад байгаа нь зарчмын хувьд зөв юм уу, буруу юм уу гэдгийг дүгнэлт дээрээ тусгаж өгнө. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Би гурван асуулт асууя.

Нэгдүгээрт нь, Хөдөө аж ахуйн яамнаас асууя. Энэ малын гаралтай түүхий эдийн экспортын асуудал ирэх жил ямархуу байна вэ, байх вэ? Одоо ингээд малчдын маань гол асуудаг асуулт энэ үйлдвэрүүд, энэ түүхий эдийн үнэ ханш ямархуу байх ийм төлөвлөгөөтэй төлөвтэй байна вэ гэдгийг асууя.

Хоёрт нь, Сангийн яам, Зам, тээврийн яамнаас асууя. Сангийн яамны эрэмбэлж байгаа асуудал бол маш зөв байна.

Тэгээд Монгол Улсын экспортын хоёр дахь том боомт Гурвантэс, Шивээхүрэн рүү явж байгаа замыг сая гайгүй тавиад эхний төсөл дээр орсон боловч одоо хассан байх юм.

Мөн дараагийн хоёр дахь эрэмбээрээ явж байгаа аймаг хоорондын зам буюу Говьсүмбэр аймгийн төв Чойр хот, Дундговь аймгийн төв Мандалговийн зам бас тодорхой хэмжээнд тавигдсан байсан. Бас үүнийг авчихсан байна.

Тэгэхээр энэ одоо яг өөрсдийн чинь хэлсэн боомтууд руу чиглэсэн замаа нэгдүгээрт тавина.

Хоёрт нь, аймаг хоорондын замаа тавина гэххээд энэ дээр хасдаг нь яаж байгаа юм бэ? Мөн говийн бүсээс улсад төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлчихсэн байна. 1.9 их наяд төвлөрүүлдэг. 5 аймгаас төвлөрүүлдэг байсан. 6 аймаг байсан. Нэг аймгийг нь улсаас дотаци авдаг болгосон байна.

Тэгэхээр улсад төвлөрүүлдэг бүс нутгийнхаа ард иргэдэд алтыг нь аваад авдрыг нь хаях энэ сэтгэл чиглүүлж байгаа юм биш биз дээ. Одоо том том төслүүд бүгд энэ говийн бүсүүдэд явна.

Тэгээд ард түмэнд яг юу гэж хэлэх вэ? Энэ дээр тайлбар хэлээч ээ.

Хөдөө аж ахуйн яам эхлэх үү? Сангийн сайд 5 номерын микрофон.

**Б.Жавхлан:** Р.Сэддорж даргын асуултад хариулья.

Говийн бүс маань сүүлийн жилүүдэд төсөвт төвлөрүүлдэг орлого бол үлэмж нэмэгдэж байгаа.

Өөрөөр хэлбэл энэ нутгийн ард түмэн Монгол Улсын хөгжилд томоохон хувь нэмэр оруулж энэ уул уурхайд нэлээдгүй ээлтэй бодлого баримталдаг ийм бүс нутаг.

Тэгээд ер нь яах вэ, бүс нутгийн хувьд одоо энэ АМНАТ юм уу, бусад уур уурхайгаас олж байгаа орлогуудыг аль болох эргүүлээд хаана ээлтэй байна тэр лүү нь түлхүү тавьж байгаа ийм зарчим огт хөдлөхгүй байгаа зүйл биш. Бид үүнийг жил бүр үүнийг сайжруулаад явж байгаа.

4 жилийн өмнөхтэйгөө харьцуулах юм бол хамаагүй дээрдсэн байгаа.

Харин цаашдаа нөгөө 40 хувийг буцаагаад хуваарилдаг болсонтой холбогдуулж энэ тоо бол нэлээн том нэмэгдэж байгаа. Энэ дээр мэдээж бодлогын шилжилтүүд дараа дараагийн удаа хийгдэнэ. Ялангуяа АМНАТ-ыг буцаад хуваарилалт дээр 70, 30 байх уу, 80, 20 байх уу гээд ийм бодлогын тооцооллуудыг нэгдүгээрт хийж байгаа. Ийм зүйлийг хэлэх байна.

Тэгээд тодорхой 2 төсөл дээр асуулаа.

Тэгэхээр ингэсэн байгаа. Уг нь бид нэг замын 22 төсөл өргөн барьсан юм. Эндээс ингээд ер нь 8 нь буцаж байна. Хойшлогдож байна гэсэн үг.

Нэгдүгээрт тавьсан шалгуур нь тухайн төсөлтэй давхцаад юм уу, зэрэгцээд тэнд төсөл явж байгаа. Эсвэл тэнд хуучин нэгэнт суурилагдсан дэд бүтэц байгаа бол нэг жил хойшлуулж байгаа.

Дархан, Алтанбулагийг би түрүүн хэлсэн. Яг л ийм шалтгаанаар хойшилсон. Шивээхүрэн рүү чиглэсэн Гурвантэсийн зам дээр одоо орон нутгаас санхүүжилт хийгээд төсөл нь бас эхэлчихсэн явж байгаа.

Одоо юу юугүй бүх төсөл нь зогсож байгаа биш. Улсын төсвөөс нэмэлтээр санхүүжүүлж замыг нь дуусгая. Ачааллыг нь хуваарилъя гэж байсан маань одоо энэ удаа түр хойшилж байна гэсэн үг.

Мандалговь, Чойрыг та хэлж байгаа. Мандалговь, Чойр, Өвөрхангай, Өвөрхангайгаас эргээд Мандалговь руу чиглэсэн энэ замууд энэ жил эхэлсэн байгаа. Энэ жил эхэлсэн. Ирэх жил үргэлжилнэ. Ор тас бас төсөл нь зогсохгүй.

Энд уг нь бид бүсийнхэнтэй ярилцаад ирэх жил хүчлээд нэмээд улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийгээд Мандалговь, Чойрын замыг хурдхан шиг ашиглалтад оруулъя гэж байсан боловч бас яг ийм шалтгаанаар, одоо өөрөөр хэлбэл бага ч гэсэн дүнгээр үргэлжилж байгаа ийм ажил байгаа учраас нэмэлт ажлыг нь нэг удаа хойшлуулъя гэдэг ийм шийдвэр өргөн барьсан гэсэн үг.

Ер нь Монгол Улс маань өөрөө бид нэг улс. Нэгдсэн улсын дүрмээр биш. Өмнөговьчуудын орлого төвлөрүүлж байгаа энэ төсвийн орлогоор өөр бусад бүх

аймагт, Баян-Өлгий аймаг, Дорнод аймагт сургууль, цэцэрлэг барьдаг. Төрийн албан хаагч нарыг санхүүжүүлдэг энэ том төсвийн орлого дотор томоохон байр суурь эзлээд явж байгаа гэдгийг хэлье.

**Р.Сэддорж:** Ж.Энхбаяр сайд 4 номер.

**Ж.Энхбаяр:** Хүнс, хөдөө аж ахуйн салбар маань хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан, мал эмнэлэг, ургамал хамгаалал, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо гэсэн ийм салбарын бодлого үйл ажиллагаа зохицуулж байгаа.

Нийтдээ дотоодын бүтээгдэхүүний 30.8 хувийг үйлдвэрлэж, экспортын 6.4 хувийг хангаж байгаа ийм салбар.

Нийт ажиллах хүчний 46.7 буюу 600 мянган хүн энэ салбарт ажиллаж байна.

Ингэснээр хамгийн том олгогч, нийгмийн тогтвортой байдлыг хангаж байгаа салбар байгаа юм.

Үүний зэрэгцээ жилдээ 990 гаруй сая долларын экспорт хийдэг ийм салбар болсон. Энэ дотроо гол тэргүүлж байгаа нь ноолуурын үйлдвэрлэл, ноосны үйлдвэрлэл, ноолуурын болон махны үйлдвэрлэл экспортын гол хувийг бүрдүүлж байна.

Ер нь ноолуур дээр зах зээлийн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ж.Энхбаяр сайдын хариултыг нэмж өгье. Гүйцээж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ноолууран дээр зах зээлийн байдал туйлын эвтэйхэн тогтвортой болсон. Өнгөрсөн жил 404 сая долларын ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт хийгдсэн.

Цаашдаа Эдийн засгийн байнгын хороо анхаарах нэг зүйл байгаа. Монгол Улс 100 хувь ноолуураа угааж байгаа. Мөн 100 хувь самнах хүчин чадал бүрэн суурилагдсан.

Энд Монгол Улс зөвхөн самнасан ноолуурыг экспортод гаргах бодлогыг нэг жил өнгөрсөн хугацаанд хойшлуулсан.

Тэгэхээр энэ шийдвэрийг яаралтай ойрын үед бид оруулж ирж энэ асуудлыг шийдвэрлүүлнэ. Ингэх юм бол Монгол Улс ноолуураа 100 хувь самнадаг, 100 хувь угаадаг, самнадаг.

Улмаар бид ээрэх хүчин чадлаа нэмэгдүүлэх, улмаар сүлжих эцсийн бүтээгдэхүүн дээрээ гол анхаарал тавих бололцоо бүрдэнэ. Үүний төлөө “Цагаан алт” гэдэг том үндэсний хөдөлгөөн, хөтөлбөр хэрэгжиж байгаа. Ноолуур, тэмээний

ноос, сарлагийн хөөвөр, нэхий, арьс ширнийхээ боловсруулалтын түвшинг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ж.Энхбаяр сайд гүйцээгээд хариулчих. Тийм ээ. Чухал асуудал ярьж байгаа учраас.

**Ж.Энхбаяр:** Ингээд сайжруулах бодлого маань “Цагаан алт” гэдэг бодлогоороо хэрэгжээд явахаар төлөвлөгдөөд 2025 оноос үйл ажиллагаа эхэлнэ.

Нөгөө нэг том боломж бол махны зах зээлийг нэлээн сайн идэвхжүүлж байна. Махны зах зээлийг тэлэх ажлууд хийгдэж байгаа. Ойрх Дорнод, Арабын хойг, Төв Ази, Зүүн Өмнөд Ази болон хоёр хөршийн чиглэлээр махны экспорт идэвхжиж байгаа. Нийт 360 сая долларт махны экспорт хүрсэн.

Цаашдаа бид мал эмнэлгийнхээ үйл ажиллагааг нэлээн чамбайруулаад, бодлого тактикаа зөв хэрэглэж аваад дотоодоосоо энэ вакцин үйлдвэрлэлийнхээ чадавхыг нэмэгдүүлээд явахад махны экспортыг багаар бодоход 500 сая долларт хүргэх, жилдээ 18 сая хүргэж мал эргэлтэд оруулах ийм бололцоо үүсэж байгаа.

Ингэхийн тулд мэдээж газар тариалан дээрээ том бодлогын асуудлыг шинээр эхэлж байна. Энэ нь тэжээлийн талбай, тэжээл таримлыг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Баярлалаа.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Мөн төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя.

Саналаа тайлбарлаж болно. Санал өгсөн бол.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал гаргасан гишүүн саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

Н.Батсүмбэрэл гишүүний микрофоныг нээе.

**Н.Батсүмбэрэл:** Зарчмын зөрүүтэй санал байна.

Сая энэ манай Байнгын хорооны ажлын албаны нөхдүүд Сангийн яамнаас мэдээллийг нарийн гаргаад аваад ирэг.



Зарим салбарынх нь нийт төсөв бараг үүнээс бага байгаа. Хүүхдүүдийг соёлын үйл ажиллагаанд хамруулъя гэж хэлснийхээ төлөө Соёлын сайд Ч.Номин янз бүрээр доромжлуулаад байдаг.

Хэвлэл мэдээллийг 8 тэрбумаар худалдаж авъя гэсэн Үндэсний хороо зүгээр суугаад байж таарахгүй. Энэ бол ичгэртэй явдал.

Их Хурлын гишүүд ээ, шударга ёс, шударга зарчим ярьдаг хүмүүс энэ дээр маш тодорхой байх ёстой. Яахаараа хэвлэл мэдээлэлд 8 тэрбум төгрөг зардаг юм. Түүний оронд тэр мөнгийг орон сууцгүй яваа иргэдийг орон сууцтай болгох ипотекийн зардал нэмэгдүүлье л дээ. Хэдэн айл, хэдэн залуу үржилсэн орон сууцтай болог нэг хороо ийм хэмжээний зардал гаргадаг байж болохгүй.

Тийм учраас тэр П.Сайнзориг гишүүний яриад байгаа элдэв янзын хороодыг татан буулгах цэгцлэх, нэгтгэх асуудлыг ярих ёстой юм.

Яагаад Шадар сайдаар толгойлуулсан нэг хороо 8 тэрбум төгрөгийг хэвлэлд зардаг юм бэ? Яагаад энэ шударга ёс ярьдаг хүмүүсийн хажуугаар өнгөрөөд байгаа юм бэ? Яагаад хууль хэрэгжүүлэх ёстой аудит чимээгүй байгаад байгаа юм бэ?

Ийм учраас тэр 8 тэрбум төгрөгийг хасаж, оронд нь олон арван айл өрхүүдэд хэрэгтэй байгаа ипотекийн зардалд нэмэгдүүлэх саналыг гаргаж байна. Үүнийг дэмжихийг Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд уриалж байна.

**Р.Сэддорж:** Бичгээр ирсэн дарааллын дагуу санал хураалт явуулъя. Ирж байгаа юм байна. Тийм ээ. Н.Батсүмбэрэл гишүүн.

Нэгдүгээр санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 18.1 дэх заалтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого, төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Г.Лувсанжамц гишүүн саналаа тайлбарлая.

**Г.Лувсанжамц:** Оройн мэнд. Би 3 санал оруулсан юм. Гурвуулаа төсвийн төслийн хавсралт нэгд орж байгаа алдаатай шалгуур үзүүлэлтийг засъя аа л гэсэн зүйлүүд.

Мөнгө нэмье, хасъя гэсэн тийм зүйлүүд байхгүй. Зүгээр шалгуур үзүүлэлтээ зөв болгоод л явах ёстой гэсэн тийм 3 санал байгаа шүү. Дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Р.Сэддорж:** Г.Лувсанжамц гишүүний гаргаж байгаа санал бол “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 2021 оны 12 сарын 30-ны өдөр гаргасан 10 жилийн бодлогын баримт бичиг байна л даа.

Тэгээд үүнтэй давхцаж байгаа юм болов уу? 10 жилийн бодлогын баримт бичигт орсон байна. Нэмэлт тайлбар. Г.Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээр 8 ширхэг 10 жилийн буюу дунд хугацааны хөтөлбөр буюу зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах ёстой гээд 2020 оны хуулиар гаргасан.

Тэр дээр туссан 8 зүйлийг хэлж байгаа юм шүү. Шинэ сэргэлтийн бодлогынх биш шүү.

**Р.Сэддорж:** 2021 онд 10 жилийн хөтөлбөрөө баталсан байна. Тийм. 2031 он хүртэл дунд хугацааны мөрийн хөтөлбөр.

Гишүүн өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд 2021 онд баталсан энэ тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг санаачилж хуралд оруулж болох юм байна.

Тийм учраас тэгээд саналаа татах уу? Өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр санал хураалт. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 18.1 дэх заалтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого бодлого төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт. /алх цохив/

33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ирц 84 хувьтай гэж байна. Ирцийн санал хураалт явуулъя. /алх цохив/

21-ээс 10 хүн байна. 10 хүн байна уу, 12 байна уу? Р.Батболд гишүүн байна. 12 гишүүн байгаа юм байна.

3 минут. Ирцээ нэмэгдүүлье Байнгын хорооны ажлын албаныхан. 3 минут. Танхимд 12 гишүүн байна. Ирц хүчинтэй байна аа гэсэн үг.

М.Бадамсүрэн гишүүн санал хураалтдаа оролцоорой. Ч.Лодойсамбуу гишүүн.

Одоо дахиад ирцийн санал хураалт. Црцээ өгөөрэй. Ирцийн санал хураалт. 21-ээс 10 байгаад байна. Н.Батсүмбэрэл гишүүн орчих юм байна. Ингээд ирц хангалттай юм байна. М.Мандхай гишүүн ажиллаагүй юм байна. 13 болж байгаа юм байна.

Ингээд хоёр дахь санал хураалтыг уншъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрд “хэмжих нэгж, тоо” гэж, суурь онд “2023” гэж, “суурь түвшин” гэж, “зорилтот түвшин 200” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Гишүүн саналаа тайлбарлая. Г.Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Саяынхтай адилхан зарчмын зөрүүтэй санал.

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлъё гэж байгаа. Энэ дээр байгаа 38.1.2 дээр хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал хэвшлийг суулгаж, хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоог бууруулна гэж зорилт тавьж байгаа мөртлөө шалгуур үзүүлэлтийгээ болохоор төхөөрөмж, хэрэглүүр, нийлүүлэлтийн биелэлт гэж.

Энэ хоёр хоорондоо нийцэхгүй логикийн алдаатай байгаад байгаа учраас хэрвээ ямар нэгэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа бол үүндээ нийцсэн шалгуур үзүүлэлт тавья гэсэн тийм санал. Энэ болон үүний дараагийнх.

**Р.Сэддорж:** Гишүүд анхааралтай. Санал хураалт эхэллээ.

Саяын саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Б.Мөнхсоёл гишүүн дэмжсэн санал өгсөн байна. Өгснөөр тэмдэглэе гэж байна. Горимын санал гаргана. Б.Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Ирц тэртээ тэргүй дутмаг байна.

Хоёрдугаарт, ганц хоёр суудаг хүн суудлаас босчихлоо. Дахин санал хураалт явуулъя гэсэн горимын санал гаргаж байна.

**Р.Сэддорж:** Төхөөрөмж ажиллахгүй байна гэсэн үг. Тийм үү.

Ингээд саяын Г.Лувсанжамц гишүүний гаргасан хоёр дахь саналаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ саналаа хүчингүй болгоно шүү дээ. Эхлээд. Тийм ээ.

Ингээд хоёр дахь санал буюу саяын сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт.

57.1 хувийн саналаар санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд дахин саналын томьёололыг уншъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрд хэмжих нэгж тоо гэж, суурь онд 2023 гэж, суурь түвшин гэж, зорилтот түвшин 200” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт.  
/алх цохив/

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гурав дахь санал хураалт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах гэсэн агуулга бүхий 38.1.2.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзан мөрд хэмжих нэгж, тоо гэж, суурь онд 2023 гэж, суурь түвшинд 780 гэж, зорилтот түвшинд 300 гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Гишүүн саналаа тайлбарлая. Г.Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Ер нь энэ саналаасаа гадна бас хэлмээр юм байна.

Төсөв өргөн бариад ийм шалгуур үзүүлэлтийн алдаатай зүйлүүд гараад, ямар үр дүнд хүрэх гэж байгаа нь алдаатай байна гээд хэлээд, үүнийгээ засах ёстой гээд санал оруулаад ирэхээр гишүүд нь Байнгын хороон дээрээ байхгүй.

Тэгээд санал хураахаар чухал юмнууд нь унаад байна шүү дээ.

Осолд өртөж байгаа хүүхдийн тоог буулгая гээд байгаа шүү дээ. Зорилт тавьж байгаа бол зорилтыгоо шалгуур үзүүлэлтээ зөв хэмжээд, үр дүндээ хүрье гээд хэлээд байгаа шүү дээ.

Энд байгаа гишүүд бүгдээрээ дэмжиж өгч байгаад баярлалаа. Бусад ирэхгүй байгаа гишүүд нь хэзээ ирэх юм.

Асуулт хариулах болохоороо хүрч ирж хариулчхаад л тэгээд явчихдаг. Зарчмын зөрүүтэй санал болохоор гишүүдийн саналыг авахгүй гээд гараад явчхаж байгаа юм уу. Энэ яаж байгаа юм.

Байхгүй гишүүдийнх нь нэрийг нь дуудах хэрэгтэй.

Энэ дээр оруулж байгаа миний санал адилхан. Хэрвээ зам тээврийн ослын бууруулъя гэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа юм бол амиа алдаж байгаа хүүхдийнхээ тоог бууруулсан түүгээрээ хэмжээ гэсэн тийм санал оруулж байгаа.

Энэ хүүхдийн амь эрсдэж байгаа нь буурахгүй байх юм бол бид төсөв тавиад, мөнгө зарлагдах ямар ч хэрэг байхгүй шүү дээ.

Ирцэд орчхоод байхгүй байгаа гишүүдийн нэрсийг зарлаад, энэ миний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг байгаа гишүүд дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Р.Сэддорж:** Одоо 21-ээс 13 байна. Хангалттай байна.

Саналаа тайлбарласан. Гишүүдийг сая зөндөө хүлээлээ. Төхөөрөмждөө бүгдээрээ ач холбогдлоо өгөөд. Одоо 13 гишүүн байна.

Хүүхдийн талаар чухал санал оруулж ирсэн байна. Н.Батсүмбэрэл гишүүн горимын санал.

**Н.Батсүмбэрэл:** Надад горимын санал байна.

Нэгдүгээр сая Г.Лувсанжамц гишүүний яриад байгаа үндэслэлтэй бөгөөд зөв.

Хуралдаанд орж ирж үгээ хэлчхээд, асуултаа асуучхаад гараад явчхаж байгаа энэ гишүүдийнхээ нэрийг зарла. Байнгын хороон дарга.

Аль эсвэл энэ хурлаа завсарлуулаад, маргааш санал хураалтаа явуул. Үгүй бол наадах явах ёстой саналаасаа давчихсан өөр эрх ч гэж юу байдаг юм. Тэр хурал даргалагч хурлын ажлаа.

**Р.Сэддорж:** Ирц хангалттай байна. Санал хураалт.

Г.Лувсанжамц гишүүний гаргасан гурав дахь санал. Санал хураалт.

Гишүүд итгэл үнэмшлээрээ санал өгч байгаа.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв дэх санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 17.1 дэх заалтын 17.1.1 дэх заалтад төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт гэсэн агуулга бүхий 17.1.1.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрд хэмжих нэгж хувь гэж, суурь он 2023 гэж, суурь түвшин гэж, зорилтот түвшин 20 хувь гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Саналаа тайлбарлах уу? Г.Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Саяынхтай яг адилхан.

Алдаатай шалгуур үзүүлэлттэй ийм төсвийн төслийг залруулъя, засъя л гэж байгаа юм.

Тэгээд дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Р.Сэддорж:** Саяын уншсан томъёоллоор санал хураалт. /алх цохив/

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Протокол П.Сайнзориг гишүүнийг дэмжсэнээр оруулъя.

Дараагийн бичгээр ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал.

Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн хоолны материалын худалдан авах зардлыг 10 хувь буюу 31.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа.

Нийгмийн бодлогын байнгын хороон дээр санал хураалт ороод дэмжигдээгүй юм байна. Тийм ээ.

Д.Үүрийнтуяа гишүүн саналаа тайлбарлах уу? Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

**Д.Үүрийнтуяа:** Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ оройн мэнд хүргэе.

Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бол яг энэ томъёоллоор ороогүй юм. Арай өөр томъёоллоор орсон байгаа юм.

Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн хоолны материал худалдан авах зардал 10 хувь зардлыг бууруулж байгаа нь нөгөө урсгал зардлын бууралтад орчхож байгаа юм.

Тухайлах юм бол дотуур байрны нэг хүүхэд өдрийн 3 хоол, 2 ундыг 4300 төгрөгөөр идэж байгаа. 4300 төгрөгийн материалаар.

Сангийн яам сая харин 2025 оны төсвийг боловсруулахдаа 6600 болгож нэмж оруулж ирсэн юм билээ.

Гэтэл үүнийг сая дахин төсвийг танах ёстой гээд 10 хувиар дахиад бууруулчаж байгаа юм. Үндсэндээ 6 мянган төгрөг хүрэхээ больчихож байна аа гэсэн үг.

Тэгэхээр бүтэн өдөржингөө гэрээсээ хол байгаа дотуур байрны хүүхэд 6 мянган төгрөгийн хоолонд өдрийн 3 хоол, 2 унд идэж цадах уу. Энэ нөгөө хүнс тэжээлийн дутагдал, хүүхдийн эрүүл өсөж бойжих эрүүл мэндийн асуудал гээд ингээд олон асуудлууд энд ард нь байгаа юм.

Монголд эрүүл хүнийг төлөвшүүлж бэлтгэхэд бид ядаж хүүхдийнхээ хоолны зардлаас хасмааргүй байгаа юм. Нөгөө талдаа эх үүсвэрийг нь би хаанаас гаргах вэ гэхээр би сая Нийгмийн бодлогын байнгын хороон дээр 4 зардлын нэгээс нь тодорхой гаргах гэдэг санал гараад энэ унасан. Тухайн зардалтай холбоотойгоор унасан гэж ойлгож байгаа.

Тийм учраас би Үндэсний аудитын газрын төсөвт хийсэн тайлангийн дүгнэлт хэсгийн 13 дахь зүйл дээр заасан байгаа. Зураг төсөвгүй, төсвийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүд төсөвт тусгагдсан байна гэж байгаа. Би үүнийг Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Үндэсний аудитын газраас яг тодорхой ажлуудаар нь, дүнгээр нь авсан 4 төсөл арга хэмжээ 99.2 тэрбум төгрөгийн 4 төсөл арга хэмжээ байгаа.

Тэгэхээр энэ 99 тэрбум төгрөгөөс 31.4-ийг хүүхдүүдийн хоолны зардлыг бууруулахгүй төлөвлөсөн хэмжээнд, ядаж 6600 төгрөгөөр нь баталж өгөөч ээ гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байгаа юм.

Тэгээд эрхэм Эдийн засгийн байнгын хорооны гишүүд маань “Хүүхдийн төлөө 3А” гэж хэлж, миний энэ гаргасан саналыг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Төсвийн хуулиараа бид төсвийн шаардлага хангахгүй зураг төсөлгүй ажлыг төсөвт тусгаж оруулж ирэхийг хуулиараа хориглодог.

Тэгэхээр хуулиар хориглосон асуудал дээр л зарчмын зөрүүтэй санал эх үүсвэр талд нь гаргаж байгаа гэдгийг ойлгоорой гэж хүсье.

**Р.Сэддорж:** Д.Үүрийнтуяа гишүүн нэмээд тайлбарлачих.

**Д.Үүрийнтуяа:** Төсвийн хуулийг зөрчиж орж ирсэн гэж үзээд байгаа аудитын дүгнэлттэй ажил бол 4 ажил. 99.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй.

Миний оруулж байгаа зарчмын зөрүүтэй санал бол 31.4 тэрбум. Улсын хэмжээний энэ хүүхдийн хоолноос хасаж байгаа 10 хувийг нэмэхэд 31.4 тэрбум төгрөг л хэрэгтэй байгаа юм.

Тэгээд энэ 99-өөс л 31.4-ийг нь авч тавих санал гаргаж байгаа гэсэн үг.

**Р.Сэддорж:** Их Хурлын дэгийн тухай хуулиар бол энэ Байнгын хороон дээр санал хураагдсан саналыг энд дахиж оруулж ирж санал хураахгүй л гэж байна лээ.

Их Хурлын тухай хуулиар эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй, манай Байнгын хороонд хамаарахгүй асуудал гэсэн ийм хоёр хуулийн заалт гарч ирж байна.

Д.Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Нийгмийн бодлогын байнгын хороон дээр зөвхөн тэр нэг олон улсын хурал зохион байгуулах гээд байгаа 50 тэрбумын байрны асуудал байгаа шүү дээ. Байгаль орчны чиглэлээр.

Тэр орж ирсэн юм. Би тэр зардлаас гэдэг томъёоллоор гаргасан юм. Тэгээд унасан юм. Энд оруулж ирэхдээ би эх үүсвэрээ өөр байдлаар тодорхойлж байгаа.

Тэгэхээр өмнөх Байнгын хороонд унасан саналыг дахин оруулж байгаа асуудал нэгдүгээрт биш.

Хоёрдугаарт, Эдийн засгийн байнгын хороо бол бас энэ эдийн засаг, төсөвтэй холбоотой асуудлыг би авч үзэх чиг үүрэгт нь хамаарна гэж үзэж байгаа. Яагаад энэ хамаарахгүй байгааг бас тайлбарлаад өгвөл би Төсвийн байнгын хороонд хандъя.

**Р.Сэддорж:** Ажлын албаны микрофоныг нээе. Д.Үүрийнтуяа гишүүн энэ хууль дээр болохгүй л гээд байна. Болохгүй заалт болчихоод байна.

Тэгье. Тайлбарыг нь яг хуулийн хүрээнд нь гаргаад өгье.

Дараагийн санал хураалт.

**Д.Мягмарцэрэн:** Ер нь Их Хурлын тухай хуулийн эрхлэх асуудлын хүрээгээр хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх тухай асуудал бол Эдийн засгийн байнгын хороонд нэгдүгээрт хамаарахгүй байгаа.



Хоёрдугаарт, Нийгмийн бодлогын байнгын хороон дээр хураагдчихсан саналыг дахиад Эдийн засгийн байнгын хороон дээр хураах боломжгүй.

**Р.Сэддорж:** Юу яах юм байна. Төсвийн байнгын хороон дээр дахиж санал хураалгах боломжтой байгаа юм байна. Ажлын хэсэг рүү таны саналыг явуулаадахъя. Гишүүн. Дэмжигдээгүй саналыг дахин хураана.

Тодорхой тайлбар явуулъя. Тань руу.

Дараагийн санал хураалт байна. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл.

Эрчим хүчний үндэсний хорооны мэдээлэл сурталчилгааны зардал 8.8 тэрбум төгрөг гэдгийг 400 саяар бууруулах. Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх, стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургах стандартыг ашиглаж хэвшүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоо бий болгох гэсэн зардалд шилжүүлбэе гэсэн. Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргажээ.

Төсвийн төсөл дээр Эрчим хүчний үндэсний хорооны мэдээлэл сурталчилгааны зардал гэсэн зардал байхгүй, заалт байхгүй юм байна. М.Энхцэцэг гишүүн ээ, ийм заалт байхгүй байгаа юм байна.

Одоо таны тэр бууруулах гэж байгаа зардал, хэвлэл мэдээллийн сурталчилгааны зардал гэсэн ийм суусан зардал байхгүй байгаа юм байна. Саналаа тайлбарлах уу? М.Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Нэгдүгээрт, би ямар ч байсан гаргаж байгаа саналаа Та бүхэнд тайлбарлая.

Та бүхэн мэдэж байгаа. Хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр, мөн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөн дээр бид энэ заалтыг оруулсан байгаа. Юу гээд тэгэхээр цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маань сүүлийн үед маш их гарч байгаа. Тийм үү. Дөнгөж сая Шангри-Ла шатлаад л гэсэн. Харин тийм. Үүнийг би түрүүний төсвийн хэлэлцүүлгийн үед энэ саналыг гаргаад тэгээд гол нь нөгөө нэг хасах юмаа би Нямбаа даргынхаас айгаад тэгээд унагачихсан шүү дээ.

Тэгээд одоо болохоор бүхэл бүтэн ингээд 8.8 тэрбумыг одоо Пи Арын зардал дээр гэсэн учраас үүнээс хасаад хэдүүлээ энэ нэг одоо асуудалтай юмыг цэгцэлбэе. Цахилгаанд маш их хүн хүүхэд цохиулж нас барж байгаа шүү дээ.

Тийм учраас одоо нөгөө манай энэ Байнгын хорооны ажлын одоо Байнгын хорооны гишүүд маань энэ зарчмын зөрүүтэй саналыг бол маш сайн мэдэж байгаа. Би үүнийг бол одоо бүр ёстой хавраас хойш тасралтгүй ярьж байгаа.

Тэгээд одоо энэ дээр ингээд 400 саяар стандартууд. Би одоо яг хаашаа хийх гэж байгааг нь хэлж өгье. Тийм ээ.

Нэгдүгээрт болохоор бид яагаад энэ гал түймэр гараад байгаа юм бэ, яагаад хүүхэд тогонд цохиулаад байгаа юм бэ гэдгийг нэгдүгээрт стандарт. Бидэнд стандартын орчин үеийн түвшинд болгож шинэчлэх ёстой.

Хоёрдугаарт нь, тэр стандартаар хүмүүсийнхээ тархийг цэнэглэхгүй бол тэр стандарт хэзээ ч бодит амьдрал дээр хөгжлийг авчрахгүй, өөрчлөлтийг авчрахгүй.

Тийм учраас сургалтын материалыг нь бэлдэх ёстой, сургагч багшийг нь бэлдэх ёстой, нөгөө техникийн их сургуульд нь сургалтын төвүүд нь хичээл ордог болох ёстой, нөгөө зураг төслийн компаниуд нь барилга угсралтын компаниуд нь бодит байдалд хэрэглэдэг.

Тэгээд нөгөө ашиглалтыг хариуцдаг цахилгаан түгээх компаниуд нь орон сууцын конторууд нь яг бодит байдалд өнөөдөр одоо цахилгаанд цохиулж хүн нас барахаар байгаа юм уу, стандартын түвшинд байгаа юм уу гал түймэр гарахаар байгаа юм уу гэдэг дээр яг стандартаа ойлгочихсон, тархиа цэнэглэчихсэн нөхцөлд үнэлгээ хийгээд тэрийгээ урьдчилан сэргээх арга хэмжээ аваад явдаг тэр тогтолцоог бий болгох ёстой байгаа.

Тийм учраас энэ ажлыг хаана хийх ёстой вэ гээд тэгэхээр Барилга, хот байгуулалт, одоо нөгөө орон сууцын яаман дээр барилгын дотор цахилгаан хангамж маань тэнд одоо хариуцуулдаг.

Тэгээд одоо байгаа стандарт нь бол нөгөө л дээр үеийн Оросынхоо баахан коэффициентоор юу яадаг тийм ээ, тэрүүгээр явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол том хэмжээний тогтолцооны өөрчлөлт реформын ажил хийгдэх ийм ажил байгаа юм.

Тийм учраас үүнийг Та бүхэн минь дэмжиж өгөөрэй.

Тэгээд тэр нөгөө хасах зардлыг бол яалт ч үгүй 8.8 тэрбум байгаа. Төсөв дээр байгаа гэдгийг тэр Сангийн яамны хүн маань өөрөө бас түрүүн одоо баталгаажуулаад хэлээд өгсөн учраас үүнийг дэмжиж өгөөрэй гэж Байнгын хорооныхоо гишүүдээс хүсэх байна.

**Р.Сэддорж:** Сангийн яам энэ дээр хариулт хэл хэлээрэй. Сангийн яам.

Сангийн яам юу яая. Санал гаргасан гишүүнд одоо наад материалаа өгчих. Тийм. Тайлбар авахгүй. Хорооны зардлаас байгаа юм бол хорооны зардлаас авна гэсэн үг тийм үү? Шилжүүлнэ гэсэн үг. Тийм ээ.

Хэвлэл мэдээллийн зардал биш юм байна шүү. Эрчим хүчний үндэсний хорооны зардлаас 400 сая төгрөгийг цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гаргах ба цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх, стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх, стандартыг ашиглаж хэвшүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоо бий болгох төсөлд зориулъя гэсэн ийм саналыг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг гаргасан байна.

Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. М.Энхцэцэг гишүүний гаргасан саналаар санал хураалт. /алх цохив/

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Горимын санал П.Сайнзориг гишүүн гаргах уу? П.Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

**П.Сайнзориг:** Төхөөрөмж дээр улаан асчхаад хугацаанд нь ингээд хуруу орсонгүй.

Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгнө үү.

**Р.Сэддорж:** П.Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох томъёоллоор санал хурааж байна. /алх цохив/

Зарчмын санал нэг л удаа дэгээрээ гарна. П.Сайнзориг гишүүн гаргасан саналыг одоо давхардаж гаргах боломжгүй юм байна. М.Энхцэцэг гишүүний санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт. Баянхонгор аймгийн Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам. Төсвийн 16.1.1.25 дээр Баянхонгор аймгийн Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам 54.1 километр. Баянхонгор аймгийн Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт гэсэн энэ сумдад харьяалагддаг юм байна.

3 тэрбум төгрөгийг хасаж, аймгийн төвд баригдаж байгаа Дулааны станцын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээ. Баянхонгор аймгийн төвд.

Ийм саналыг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар гаргасан байна. Д.Цогтбаатар гишүүн саналаа тайлбарлая.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе.

Солонгосын ЭКСИМ банкны санхүүжилтээр 10 аймагт дулааны станцын ажлууд хийгдээд явж байгаа. Баянхонгор аймгийн дулааны станцын барилгын ажил 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа.

Тэгээд энэ 2 дугаар хэлхээний ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийнэ. Бусад 9 аймгийнх нь хийгдээд явж байгаа. Энэ 2 дугаар хэлхээнийх нь зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт нь гараагүй байж байгаад сая 11 сарын 19-нд гарсан.

Тэгээд энэ талаар Эрчим хүчний яам, Сангийн яам, Зам, тээврийн яаманд бүгдэд нь танилцуулсан. Тэгээд тийм учраас Та бүгдийг дэмжээд энэ Баянхонгор аймагт хуримтлагдаад байгаа утааны асуудлыг шийдэхэд Та бүгдийг дэмжиж саналаа өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан саналын томъёоллоор.

Гишүүд анхааралтай байгаарай. Саяын гаргасан саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Гишүүд санал хураалтад идэвхтэй байгаарай. М.Энхцэцэг гишүүн, Сангийн яамны М.Санжаадорж дарга хоёр наад юмныхаа учрыг олоорой. Гишүүд дэмжихгүй байна шүү дээ. Зарим нь. Тэгээд үүний учрыг нь олоод бас ойлголцолд хүрэх хэрэгтэй байх аа.

Эрчим хүчний үндэсний хорооны реформын 11 тэрбум 986.1 тэрбум төгрөгийн багцаас мэдээлэл сурталчилгааны зардлын. Багцаалсан юм байна шүү. Шууд 9 тэрбумыг хасаж, хувийн хэвшлийн байгууллагад олгох дотаци 33 тэрбум байсныг 13 тэрбум болгож хасагдаж, 20 тэрбум. Энэ чинь одоо ямар.

Хувийн хэвшилд олгох дотацийг 29 тэрбум болгож нэмэгдүүлэх гэсэн ийм саналын томъёолол байна.

М.Бадамсүрэн гишүүн саналын томъёололыг тайлбарлая.

**М.Бадамсүрэн:** Байнгын хорооны гишүүд ээ,

Нөгөө ийм тийм хэвлэл мэдээлэл Пи Арын шинжтэй ийм зардал байгаа бол энэ бол байж болохгүй шүү дээ.

Тэгээд ер нь сайд нар нэг ийм мөнгө нууж боож тавиад тэгээд үүгээрээ өөрсдийгөө сурталчилдаг юм уу, ажлаа сурталчилдаг юм уу? Тэгээд олон нийтэд ийм ойлгомжгүй байдал үүсгээд байна.

Улсын Их Хурлын эрх бүхий бүрэн эрхтэй гишүүн энэ талаар мэдээлэл хийсэн байгаа. Төсвийн ажлын хэсэгт ажиллаж байгаа гишүүн. Тэгээд үнэхээр ийм байгаа бол өөр одоо бас сайд нарын багц дээрээ ийм юм байгаа ч юм билүү. Ер нь үзэх нь зүйтэй л гэж бодож байна тэгээд.

Тийм учраас үүнийг олон нийтэд хүрсэн, олон нийт эсэргүүцэж байгаа энэ зардлыг зардлыг бууруулж харин хувийн хэвшлийг дэмжих зорилгоор. Өөрөөр хэлбэл ер нь төсвийн бодлого гэдэг чинь хувийн хэвшлээ л дэмжинэ шүү дээ.

Тэгээд хэдэн дарга нар нь хэвлэл, Пи Ар дээр мөнгө зараад хувийн хэвшил нь ажил хийе гэхээр хөнгөлөлттэй зээл олдохгүй, газар олдохгүй, дэд бүтцээр дэмжиж чадахгүй байж болохгүй. Ийм зохисгүй байдлыг ялангуяа манай Эдийн засгийн байнгын хороо бол халах ёстой.

Эдийн засгийн байнгын хороо иргэдийн эдийн засгийн эрх чөлөөтэй болох боломжийг олгох ёстой. Манай гол бодлого байна гэж үзэж байгаа юм. Тийм. Хүнээ дэмждэг, хувийн хэвшлээ дэмждэг, эдийн засгийн эрх чөлөөтэй байлгадаг ийм бодлого учраас аялал жуулчлалын хүүгийн дотацид олгох ёстой 7 хувийн хүүгийн дотацид олгож аялал жуулчлалын хувийн хэвшлийг жижиг, дунд аялал жуулчлалыг дэмжих зорилготой энэ бодлогыг бид үргэлжлүүлэх ёстой гэж үзэж байна.

Тийм учраас энэ зүйлийг дэмжиж өгөхийг Байнгын хороонд гишүүдээсээ хичээнгүйлэн хүсье.

**Р.Сэддорж:** Саяын зардлыг яг ямар чиглэл рүү, юу хийж байгаа юм? Н.Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Ийм байна аа гишүүд ээ.

Сая Сангийн сайд асуулт хариултын үеэр микрофонд маш тодорхой хэлсэн. Маш тодорхой хэлсэн. Эдийн засгийн байнгын хорооны ажлын албанд би албан ёсоор хүсэлт тавья. Яг өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны бүтэн бичлэгийг надад өгөхийг хүсэж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, эрчим хүчний реформ хийнэ гэж ярьчихаад Эрчим хүчний үндэсний хороо нь 13 тэрбум төгрөгтэй. Үүнийхээ 9 тэрбум төгрөг нь зөвхөн мэдээлэл сурталчилгаанд зарна гэж юу гэсэн үг юм бэ. Хэнд зориулж энэ мөнгийг тавиад байгаа юм бэ?

Сая Сангийн яамнаас би материал үзчихлээ. Бид нарт тараасан 13 дугаар хүснэгт дээр багцаар явж байгаа. Сангийн яамны тэр 16 дугаар хүснэгт дээр 9 тэрбум нь бодитойгоор байж байгаа. Үгүй ээ тэгээд энэ шударга ёсоо бид хаанаас ярих гээд байгаа юм. Нөгөө хүнээ хамгаалдаг, хүнээ хайрладаг томъёолол чинь хаана байгаа юм.

Б.Найдалаа та нар нэг нүүртэй бай л даа. Энэ 9 тэрбумыг хасъя гэж байгаа юм. Хасъя гэж байгаа юм. Хэмнэлт яриад гарын үсэг зурахаараа зурдаг шиг тийм нэг нүүртэй бай л даа. Юуг хэн хэн хэн захиалахаараа шударга ёс болчихдог. Хэн юуг захиалахаараа хэмнэлт биш болчихдог юм. Б.Найдалаа.

Наад 9 тэрбум төгрөгийг хасъя. 9 тэрбум төгрөг хасах саналыг оруулж байгаа. Үүнийг хэд хэдэн хувилбар гишүүд оруулсан юм байна. Тэгээд тэр дараа нь яг юунд зарах вэ гэдгээ тусад нь санал хураая.

Эхлээд хасах саналаа оруулчхаад. Эрчим хүчний реформын үндэсний хорооны 11 тэрбум 986.1 сая төгрөгөөс 9 тэрбумыг хасах.

Ийм саналын томъёоллоор санал хураалт. Идэвхтэй байгаарай гишүүд. /алх цохив/

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Н.Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Яг нөгөө хэмнэе гээд байсан хүмүүс яг эсрэг дарлаа шүү. Энэ чинь Эрчим хүчний зохицуулах хороо 9 тэрбумаар мэдээлэл сурталчилгааны ажил хийнэ гэж юу байдаг юм бэ?

Энэ материалаа, яг энэ санал хураалтын дүнг надад албан ёсоор өгөхийг Эдийн засгийн байнгын хорооны ажлын албанаас хүсэж байна.

**Р.Сэддорж:** Энэ мэдээллийг Байнгын хороо ажлын алба өгье.

Санал хураалт. Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн. Уншиж танилцуулах гишүүд.

Р.Батболд гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн. Одоо байгаа нь Б.Мөнхсоёл гишүүн, Р.Батболд гишүүн хоёр байгаа юм байна. Төсвийн байнгын хорооны гишүүд. Төсвийн байнгын хорооны гишүүд Б.Мөнхсоёл гишүүн.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

---

**Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”**

**Улсын Их Хурлын тогтоолын төслүүд**

/Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

---

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг хэвээрээ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Нэг. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Үндэсний баялгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Н.Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа. Н.Батсүмбэрэл гишүүний микрофоныг өгье.

---

**Н.Батсүмбэрэл:** Би юу яая. Энэ Тамгын газрын даргыг дуудаж байна. Тамгын газрын дарга аа дуудчих. Дуудаж чаддаггүй юм бол урьчих.

Тэгээд өнөөдрийн хурлын материалыг авъя. Тэр нөхрөөс чинь. Одоо хурлын материал өгөхгүй гэж авч байна шүү дээ. Эдийн засгийн байнгын хорооны.

Гишүүд мэдээгээр хангагдаж болохгүй юм уу? Саяын санал хураалтын дүнг албан ёсоор авъя, протоколуудыг авъя, файлаар авъя, видеогоор нь авъя.

Тэр одоо яг Б.Баасандоржийг дуудаадах. Ийм эрх нь байгаа. Ажлын алба тэр Б.Баасандоржийг дууд. Тамгын газрын дарга аа. Байнгын хорооны ажлын албаны хүчин чадал нь хүрдэггүй юм байна.

Б.Баасандорж одоо үзэж байгаа бол ороод ир.

**Р.Сэддорж:** Их Хурлын Тамгын газрын дарга даргыг дуудъя.

Гишүүд шаардлагатай мэдээллээ авч болно шүү дээ. Үүнийг ажлын алба шаардлагатай юуг нь Тамгын газрын даргаар тайлбарлуулъя.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс хоёр санал ирсэн байна.

Гишүүн тайлбарлах уу? О.Батнайрамдал гишүүн саналаа тайлбарлах уу? О.Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

**О.Батнайрамдал:** Оройн мэнд. Хоёр зарчмын зөрүүтэй санал байгаа юм.

Гэхдээ ямар ч төсөвтэй холбоотой биш. Эхнийх нь болохоороо төрийн өмчийн. Эхнийх болохоор ерөөсөө ийм байгаа юм. Нөгөө төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниуд дээр олон улсын аудит хийлгэнэ гэж байгаа юм л даа.

Тэгэхээр тэрийг бол 100 хувь дэмжиж байгаа. Гэхдээ тэр аудитын жагсаалтыг нь Засгийн газар өөрөө гаргаад батална гэж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ болохоороо уг нь Аудитын тухай хуулиар ч гэсэн, Үндсэн хуулиараа энэ эрх чинь уг нь Үндэсний аудитын газар байгаа юм.

Тэгэхээр тэр жагсаалтыг Засгийн газар өргөн барьснаараа Улсын Их Хурал батлаад буцаад тэр аудитын дүгнэлтийг нь Улсын Их Хуралд тайлагнах ийм зарчмын зөрүүтэй л санал оруулсан юм.

Тэгэхээр яагаад гэх юм бол хэрвээ Засгийн газар аудитын жагсаалт, нөгөө аудит хийлгэх компанийн жагсаалтаа гаргаад өөрөө батлаад, өөрөө хүлээж авах



юм бол энэ чинь Улсын Их Хурал болон Аудитын ерөнхий газрын хуулийг нь зөрччихөж байгаа байхгүй юу. Яг төрийн өмч бол буцаад хэнд тайлагнах вэ гэвэл төрийн өмч бол буцаад Улсын Их Хуралд. Тэрний аудитыг нь хийх ёстой гэвэл Аудитын ерөнхий газраас хийх ёстой. Тийм үү.

Тэгэхээр энэ дээр Засгийн газар өөрөө тогтоогоод жагсаалтаа гаргаад өөрөө тогтооно гээд хууль дээрээ орчихсон байгаа юм.

Тэгэхээр тэрийг Улсын Их Хурал аудиттай холбож байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ урд талын юун дээр байсан даа. Бид яг урьд өмнө нь энэ дагалдах хууль дээр төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дээр энэ явж явж хамгийн том реформ энэ дээр л хийгдэнэ гэж харагдаад байгаа юм л даа.

Буцаад бид төсөв дээр нэлээн хасалт хийхээр буцаад төрийн өмчит компаниудын маш том реформыг бид хийхээс өөр гарцгүй.

Тэгэхээр энэ дээр урьд нь нэг чуулган дээр ороод хасагдсан нэг зүйл болохоороо бид нэлээн олон мэдээллийг ил тод болгоё гэж энэ нэмэлт, өөрчлөлтөөр оруулж байгаа мөртлөө яг жишээлбэл төлөөлөн удирдах зөвлөл байна.

Тэгэхээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэр болон тэдний авч байгаа цалин хөлсийг нь бас л адилхан олон нийтэд нээлттэй болгочихёе л гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ өөрөө урьд нь явж байгаад яагаад ч юм хасагдчихсан.

Тэгэхээр үүнийг буцаж нэмж одоо энэ удаа бас оруулчихъяаа гэж байгаа юм. Нэгэнтээ бид нэлээн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлтөөр бол нэлээн олон зүйлийг төрийн өмчийн компанитай холбоотойгоор ил болгож олон нийтээр ил болгож байгаа бол төлөөлөн удирдах зөвлөлийн тэр гишүүдийн мэдээлэл болон. Ер нь тэр чинь зүгээр л овог нэр авч байгаа цалин хөлс нь байхгүй юу. Тэр ч гэсэн бас ил болгох ёстой.

Тэгэхээр үүнийг яагаад ч юм бид урд талынхаа чуулган дээр бол унагаачихсан юм. Энэ хоёрыг л босгоё гэж байгаа юм. Тэр эхнийх нь болохоороо тэр Засгийн газар өөрөө тогтоогоод батлаад явчих юм бол ингэж байгаа юм л даа. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитаар аудит хийлгэе гэж байгаа юм. Маш сайн хэрэг. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчийн хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийлгэх хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтыг Засгийн газар тогтооно гэххэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь уг нь бол Аудитын ерөнхий газарт байх ёстой үндсэн зарчим шүү дээ. Төрийн өмчийг буцаад. Тэгэхээр Засгийн газар өөрөө тэн дээр аудитаас өмнө нь урд нь орж жагсаалтаа батлаад өөрөө авна гэхээр Улсын Их

Хурал болон нөгөө аудитын тэр Үндсэн хуулийн зарчим бас алдагдаж байна гэж харж байгаа юм л даа.

Тэгэхээр үүнийг Улсын Их Хурал руу оруулж ирэх ийм хоёр л зарчмын санал байгаа юм.

Тэгэхээр энэ яагаад манай дээр санал хураагдаж болохгүйг ойлгохгүй л байна л даа. Хураагаад явуулаад тэгээд Төсвийн байнгын хороон дээр яригдах ёстой байх гэж.

**Р.Сэддорж:** Б.Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Би энэ сая уг нь санал хэлэхээргүй байсан. О.Батнайрамдал гишүүний хэлсэн дээр гэнэт санаад бас нэмж хүч өгье гэж бодож байна.

Ер нь бол Үндэсний аудитын газар ч бай, Монголбанк ч бай бие даасан үйл ажиллагаатай байх ёстой.

Гэтэл энэ Үндэсний аудитын газар өөрсдөө юу, эсвэл олон улсын байгууллагаар уу, хийлгэх энэ өөрсдийн эрх үүргийн хариуцлагын хүрээнд шийдэх ёстой асуудлыг нь Засгийн газар өөрөө шийднэ. Тэгээд Засгийн газрын харьяа байгууллагуудыг аудит хийнэ гэхээр энэ өөрөө сонирхлын зөрчил байхгүй юу.

Тэгэхээр яаж ч байсан үүнийг бол Засгийн газар хэнээр юу хэлэхийг аудит дээр бол шийдэж болохгүй ээ гэдэг дээр санал нэг байна. Энэ аягүй том зарчмын асуудал шүү гэдгийг бас протоколд тэмдэглүүлмээр байна.

Чуулганаар бас Б.Түвшин гишүүн энэ асуудлыг хөндсөн.

**Р.Сэддорж:** О.Батнайрамдал гишүүн хураалгах боломжгүй саналууд байна.

Ийм учраас одоо үүнийг хуулийн зүгээс тайлбарлая.

**Д.Мягмарцэрэн:** О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Эхний аудит хийх хуулийн этгээдийг Засгийн газрын санал болгосноор Их Хурал батална гээд энэ асуудал байж байгаа. Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээний л асуудлаар санал, дүгнэлт гаргаж санал гаргаж ярих ёстой.

О.Батнайрамдал гишүүн Төсвийн байнгын хороон дээр саналаа гаргах бүрэн эрх нь байгаа. Аудитын асуудал бол Их Хурлын тухай хуулийн 23.9.7 дээр Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарна гээд заачихсан байж байгаа.

Тэгэхээр аудитын асуудлаа та Төсвийн байнгын хороон дээр саналаа гаргах эрхтэй.

---

Нөгөө хоёр дахь нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт шинээр дэд заалт нэмэх ийм санал байж байгаа.

Энэ нь чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйл гээд байнгын хороо санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаарыг тогтоогоод өгчихсөн байж байгаа юм. 40.3.3 дээр хуулийн төсөлд найруулгын саналаас бусад зүйл, хэсэг, заалт, дэд заалт нэмэхийг хориглочихсон байж байгаа. Тийм.

Угаасаа ийм саналыг хураалгах боломжгүй ээ л гэсэн үг. Дэгээрээ хориотой. Дэгийн тухай хуулиараа.

**Р.Сэддорж:** Төсвийн байнгын хороонд саналаа бичгээр өгөөд нэмж болох юм байна.

Ингээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс гаргасан саналыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Н.Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Н.Батсүмбэрэл гишүүний микрофоныг өгье.

**Н.Батсүмбэрэл:** Нөгөө алдарт Б.Баасандорж маань хаана явна. Энэ түгжрэлд явж байгаа бол тэр цагдаа явуулаад хурдан шиг замыг нь чөлөөлөөд авчраач ээ.

**Р.Сэддорж:** Б.Баасандорж дарга яасан. Ирэх юм уу, ирэхгүй юм уу? Ирье гэсэн юм уу. Хэдэн минут юм.

Хурлаа үргэлжлүүлж байя. Б.Баасандорж даргыг ирж байна гэж ойлголоо. Ирж гишүүдэд одоо үүнийг бодитой болох болохгүй тайлбаруудыг нь өгөхгүй бол гишүүдийн нэхсэн материалыг өгөхгүй байна гэсэн ийм асуудал ярьсан учраас дуудсан юм.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Одоо “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Асуулт асуух гишүүд байхгүй байна. Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналууд ирүүлсэн байна. Үүнийг хэлэлцэж эхэлье.

Санал “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэсэгт шинээр заалт нэмэх тухай.

Саналын томъёолол. Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Саналаа тайлбарлая. П.Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Би энэ саналыг хэмнэе гэж байгаа энэ концепц Улсын Их Хурал дээр бас яригдаж байгаа үе дээр шийдье гэж байгаа юм.

Өнөөдөр Эдийн засаг, хөгжлийн яам, карьертай юмнууд нь Үндэсний хороо, зөвлөл болоод гараад явчихдаг. Орон сууцжуулалтын асуудал нь Хурдасгуур төв дээр бодлого нь гарч байна гээд явж байгаа.

Ерөнхийдөө энэ төрийн албаны босгыг давж чадахгүй хүмүүсээ нэг цуглуулж нэг ийм зүйл хийж байна. Нэг талдаа. Нөгөө талдаа бас Төрийн албаны хуулийн энэ хэрэгжилтийг харж байгаа зарим зүйлүүдийг ур чадвартай хүмүүсийг яамдад ажиллуулах тэр бололцоог нь бас нээж өгмөөр байна.

Энэ зүйлүүдээс шалтгаалаад тэнд ажиллах бололцоогүй мэргэжилтнүүдийг ч юм уу, бас зарим талаараа энд ингээд одоо төрийн албаны шалгалт өгөхгүй байдлаар маш өндөр цалин энэ тэртэйгээр ажиллуулж байгаа зүйл байна. Үр дүн гарч байгаа бол би дэмжинэ. Өнөөдөр ерөөсөө үр дүн гарсангүй.

Тэгээд ерөөсөө л яамд руу бичиг явуулж, яамдын хийсэн тэр судалгаа, хийсэн ажлыг нь аваад нэг хурал зөвлөгөөн зохион байгуулаад л сүртэй сүртэй юм яриад явж байгаа.

Нэг талдаа энэ төрийн үрэлгэн зардлаасаа гадна төрийн албыг сулруулж байгаа хэсэг, нөгөө талдаа хариуцлагыг сулруулж байна. Хэн хариуцлага хүлээх вэ? Эцсийн дүндээ.

---

Би түрүүн ганц л жишээ аваад байгаа юм. Орон сууцжуудын бодлогын асуудлыг ярьж байтал өнөөдөр орон сууцжуудын зөвлөл гээд явчхаж байгаа юм. Тэгээд яг хэн хариуцах вэ?

Дээрээс нь эрчим хүчний реформ хийнэ гээд байдаг. Эдийн засаг, хөгжлийн яам хийнэ ээ л гээд байдаг. Эрчим хүчний сайд гээд нэг нөхөр байгаад байдаг. Сүүлдээ ерөөсөө энэ хоёр хийж чадахгүй бол одоо тэгээд яг альныг нь гэж барьж үзэх вэ?

Тэгэхээр ер нь зүгээр ийм зарчимгүй юмнуудыг больё. Манай танай гэж би ерөөсөө ярихгүй байгаа. Энэ жишиг бол одоо муу жишиг байхгүй юу. Жишээ нь, маш олон агентлагуудыг Н.Алтанхуяг гуайн засгийн үед буулгаад төрийн өмчит компани болоод Усны агентлагийн мэдээллүүдийг төрийн өмчит усны компанид өгөөд тэр мэдээллүүд нь буцаад агентлаг болохдоо олдоогүй. Тэр цугларч байсан мэдээллүүд ийм журмаар алга болдог, хувийн хэвшилд алдагддаг. Яг энэ зарчим өнөөдөр үйлчилж байгаа юм.

Тэгээд энэ сүүлдээ баахан цүнх барьсан. Яг үүний чинь цаана нэг байр байгаа, нэг машин байгаа. Бараг доор хаяж 44 хороо, зөвлөлөөс гадна бусад энэ дээр дурдагдахгүй байгаа тэр хурдасгуур, бүтээмж, шинэ сэргэлтийн бодлого энэ тэр гээд явах юм бол 50-иад байгууллага байна.

Үүнийг хуультайгаас нь бусдыг нь татан буулгах чиглэлийг гишүүд маань Эдийн засгийн байнгын хороо дэмжиж өгөөч ээ. Ийм л бодитой юмыг хийхгүй бол өнөөдөр байна шүү дээ бусад Байнгын хорооны хэлэлцүүлгийг хар. Боловсролоосоо танаж байна, эрүүл мэндээсээ танаж байна, хууль сахиулах салбараас танаж байна.

Өнөөдөр хүүхдийн хүмүүжлийг ярихдаа нэг үгийг би хэлмээр байгаа юм. Хүүхдийн хүмүүжил түүнийг төрөхөөс өмнө 100 жилийн өмнө эхэлдэг гээд, тэгээд боловсролоосоо өнөөдөр хасаад зогсож байна. Өнөөдөр хулгай зэлгийтэйгээ тэмцье гэхээр тэр төсвөөс нь хасаад зогсож байна. Тэгээд байгаа орчиндоо өсөж байгаа хүүхэд энэ нийгмийг энэ буруу зүйлийг үргэлжлүүлнэ л гэсэн үг.

Тэгэхээр энэ боловсролын салбараас хасаж байгаа бол энэ чинь хөгжлөөсөө асаж байна гэсэн үг. Хууль сахиулах салбараас, эрүүл мэндийн салбараас хасаж байна гэдэг бол үндсэндээ хүний эрхийг дэмжихгүй байгаатай ялгаагүй байхгүй юу.

Тийм учраас хэмнэлтийг энэ горимоос эхлэх ёстой. Учир зүггүй чиг үүргүүд нь давхцаад байгаа яам болж томроод байгаа. Бүр энэ данхайгаад байгаа шүү дээ. Зарим нь 50, 60 хүнтэй болчихлоо. Яамтай адилхан.

Тэгэхээр үүнийг эрхэм гишүүд минь дэмжээд өгөөч ээ. Тэгээд ямар ч байсан Засгийн газарт энэ чиглэл өгөх тогтоолынхоо хэрэгжилтийг Улсын Их Хурал араас нь хөөцөлдөөд явах ёстой. Ингэж яамд, агентлагуудын тоог нэмэхгүй байгаа юм шиг мөртлөө алсуураа бүтцүүдийг нэмж, чиг үүргүүд давхцаж, төсөв үргүй

зарцуулагдаж, сүүлдээ хэн нь юугаа хариуцаж байгаа нь мэдэгдэхээ байх гэж ийм зүйл рүү явж болохгүй ээ. Үүнийг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

**Р.Сэддорж:** П.Сайнзориг гишүүний гаргасан саналаар санал хураалт.

Гишүүд санал хураалтдаа идэвхтэй оролцъё. /алх цохив/

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

П.Батчимэг гишүүн горимын санал гаргая. П.Батчимэг гишүүн.

**П.Батчимэг:** Горимын санал. Төхөөрөмж ажилласангүй. Дэмжсэнээр протоколд тусгаж өгөөч.

**Р.Сэддорж:** Төхөөрөмж ажиллахгүй хүчингүй болгох санал гаргасан гэж ойлгож байна. Тийм ээ.

Ингээд сүүлийн санал хураалтыг П.Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

52.4 хувийн саналаар санал хураалт хүчингүй болж байна.

Ингээд П.Сайнзориг гишүүний гаргасан саналаар санал хураалт дахиж явж байна. Санал хураалт. /алх цохив/

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал. Тогтоолын төслийн 2 дахь хэсэгт шинээр заалт нэмэх саналын томъёолол.

Цэвэр эрчим хүч, хогноос эрчим хүч гаргах асуудлыг зохицуулах, дэмжих, ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн томъёоллоор Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санал гаргасан байна.

П.Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

**П.Сайнзориг:** Эрхэм гишүүдээсээ бас үүнийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Дэлхий нийтээрээ ногоон эдийн засаг, ногоон эрчим хүч ярьж байгаа. Өнөөдөр утаа униар, түгжрэл, энэ эдийн засгийн суурь тэлэлтийг зөв хийх энэ асуудал дээр ерөөсөө л эрчим хүчний асуудал байгаа.

Гэтэл энэ эрчим хүчний реформын төлөвлөгөө энэ тэрийг би ерөөсөө олж харсангүй.

---

Тийм учраас санаа зовоод энэ саналыг гаргаж байгаа юм. Өнөөдөр Сэргээгдэх эрчим хүчний хуулиар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр дээр нар, салхи, усны эрчим хүч, газрын гүний дулаан, биомасс л ордог юм. Яг энэ хогноос эрчим хүч гаргах асуудал бас хаягдчихаад байгаа юм.

Цэвэр эрчим хүчний эх үүсвэрийн асуудал буюу атомын цахилгаан станц асуудал одоогоор аль хуулиар явах нь тодорхойгүй байгаа юм. Үүнийг эртнээс судлаад холбогдох хууль тогтоомжийг судалж, боловсруулж орж ирээч ээ. Ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийг дэмжих тухай хууль оруулж ирээч ээ гэдэг зүйлийг Засгийн газарт чиглэл болгож байгаа юм. Дэмжээд өгөөч ээ.

Тэгээд ерөнхийдөө хогийн асуудлыг зүгээр байгаа боловч яг эрчим хүчний тэр асуудал дээр дэмжихэд бол хэцүү байна. Хог хаягдлын хуулиар хангалттай явах тийм бололцоо харагдахгүй байна. Сэргээгдэх эрчим хүчний хуулиар атомын цахилгаан станц буюу цэвэр эрчим хүчний эх үүсвэр хог хаягдлаас эрчим хүч гаргаж авах энэ асуудал үндсэндээ орхигдчихоод байгаа юм.

Тэгээд та бүгд үүнийг Засгийн газарт чиглэл болгоод, бас хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлж байж л дараа нь магадгүй 5 жилийн дараах бүтээн байгуулалтыг өнөөдрөөс ярьж байж л эхлүүлэх гээд байгаа юм.

Тийм учраас та бүгд Засгийн газарт энэ чиглэлийг дэмжээд өгнө үү. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хогноос эрчим хүч, ногоон эрчим хүч гаргах тухай маш зөв зүйтэй саналыг гаргаж байна. Өнөөдөр хэвлэл мэдээлэл гарсан юутай холбоотой байх. Тийм ээ.

Ингээд П.Сайнзориг гишүүний гаргасан хоёр дахь саналаар санал хураалт. /алх цохив/

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Лувсанжамц гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийн 2 дахь хэсэгт шинээр заалт нэмэх.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

П.Сайнзориг гишүүний гаргасан гурав дахь саналаар санал хураалт. /алх цохив/

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

П.Сайнзориг гишүүн өөрөө дэмжсэнээр санал тэмдэглүүлж байна. Тийм үү.

Одоо “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Үүнээс өмнө Улсын Их Хурлын Тамгын газрын даргыг Н.Батсүмбэрэл гишүүн тайлбар авъя гэсэн. Энэ тайлбарыг өгөхийг хүсье.

Н.Батсүмбэрэл гишүүн асуух уу? Эхлээд. Н.Батсүмбэрэл гишүүнд микрофон өгье.

**Н.Батсүмбэрэл:** Б.Баасандорж даргад баярлалаа. Хүрэлцэн ирсэн явдалд.

Нэлээн удаан хүлээлээ. Энэ Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдааны материалыг авъя гэсэн юм. Тэгсэн танаас өөр мэдэх хүн байхгүй. Таны дээр хөх тэнгэр байдаг гэж байна.

Тэгээд энэ асуудлыг нэгдүгээрт шийдэж өгнө үү. Одоо холбогдох материал, дүрс бичлэг, санал хураалтын дүнг авъя гэж байгаа.

Хоёрдугаарт, Их Хурлын гишүүдийн гаргаж байгаа саналууд дээр зарим зүйл дээр сая О.Батнайрамдал гишүүний яриад байгаа ч адилхан. Зарим зүйл дээр Байнгын хорооны зөвлөх гэх нөхөр өөрийнхөөрөө тайлбарлаж байна.

Энэ одоо зохилтой юу?

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын Тамгын газар Б.Баасандорж.

**Б.Баасандорж:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өөр хуралтай, Байнгын хороон дээр байж байгаад хоцорчихлоо. Уучлаарай.

Гишүүд хуралдааны тэмдэглэл болон дуу дүрсний бичлэг, протоколтой танилцах эрх нь нээлттэй. Гишүүн ээ.

Яг одоо өнөөдрийн энэ цаг хугацаанд болж байгаа тэмдэглэлтэй хэрвээ та танилцъя гэх юм бол тэмдэглэл өөрөө цаасан тэмдэглэлтэй юу, дуу, дүрсний бичлэгтэй юу? Аль тэмдэглэлтэй нь та танилцах вэ? Окэй.

Одоо хуралдааны бичлэг шууд явж байгаа. Сэтгүүлчдэд нээлттэй явж байгаа шүү дээ. Хуулбарлаж авбал би танд яг бүтэн бичлэгийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дуусмагц танд би яг одоо дуу, дүрсний бичлэгийг холбогдох журмынх нь дагуу буулгаад танд өнөөдөр би хүлээлгээд өгье.



Цаасан хэлбэрээр манай бичээч журамтай явна шүү. Окэй. Дуу, дүрснийхийг бид хуралдаан дуусмагц танд хүлээлгэж өгье.

**Р.Сэддорж:** Баярлалаа. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлгийг явуулж эхэлж байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Асуулт хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаан идэвхтэй оролцсон гишүүддээ.

Гишүүд суудлаа эзэлье. Ингээд П.Сайнзориг гишүүн санал гаргах уу? О.Батнайрамдал гишүүн горимын санал гаргах уу?

**О.Батнайрамдал:** Түрүүн би төхөөрөмж төхөөрөмж дээр нөгөө улаан асаад би санал өгч нөгөө чадаагүй.

Тэгэхээр тэр саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгнө үү? Баярлалаа.

Түрүүн нэг тогтоолд өөрчлөлт оруулах тухай нөгөө Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан одоо 5 дугаар тогтоолын 1 дэх заалтыг 01 сарын 06 гэснийг 12 сарын 19 гэж өөрчлөх тэр тогтоолын санал хураалт дээр төхөөрөмж гацааж саналаа өгч чадсангүй.

Тэгэхээр саналыг хүчингүй болгож дахин санал хурааж өгнө үү.

**Р.Сэддорж:** Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалт явуулахад бэлдье. Гишүүд.

Өнөөдрийн хуралдааны эхний нөгөө тогтоолын өөрчлөлтийн тухай санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн О.Батнайрамдал гишүүний горимын саналаар санал хураалт. /алх цохив/

57.1 хувийн саналаар санал хүчингүй болж байна. Дэмжигдэж хүчингүй болж байна.

“Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 03-ны өдөр баталсан 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын “2025 оны 01 сарын 06-ны өдөр” гэснийг “2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр” гэж өөрчилсүгэй. Санал хураалт.

Асуух уу? Р.Батболд гишүүн. Р.Батболд гишүүний микрофоныг өгье.

**Р.Батболд:** Наадах чинь хугацааны хувьд 14 хоног ч юм уу болохоо байчхаж байгаа юм биш үү?

Өнөөдөр чинь 6. 19-н хүртэл гэхээр чинь 14 хоног чинь болохоо байчихна шүү дээ.

**Р.Сэддорж:** 5-наас эхлээд зар явчихсан байгаа.

Тэгээд дуусах хугацааг л ярьж байгаа юм. “Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

52.4 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд Байнгын хорооны өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 45 минут үргэлжилж, 19 цаг 12 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**